



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ

ЕНШӨӨБҮ
Баярболд УЧРАЛ

ЗАХИРГААНЫ ГЭРЭЭНД ИРГЭНИЙ ХУУЛИЙН
ЗОХИЦУУЛАЛТЫГ НӨХӨН ТОХИРУУЛЖ
ХЭРЭГЛЭХ НЬ



Мэргэжлийн индекс
D042101

Эрх зүйн бакалаврын
Зэрэг горилсон
Дипломын төсөл

Удирдсан
С.Батхүлэг \Ph.D.\

Улаанбаатар. 2026



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ

ЕНШӨӨБҮ
Баярболд УЧРАЛ

ЗАХИРГААНЫ ГЭРЭЭНД ИРГЭНИЙ ХУУЛИЙН
ЗОХИЦУУЛАЛТЫГ НӨХӨН ТОХИРУУЛЖ
ХЭРЭГЛЭХ НЬ



Мэргэжлийн индекс
D042101

Эрх зүйн Бакалаврын Зэрэг
Горилсон Дипломын Төсөл

Удирдагч : С.Батхүлэг \Ph.D.\

Шүүмж : А.Билгүүн \LL.M.\

ГАРЧГИЙН ТОВЬЁГ

МЭДЭГДЭЛ	i
ТАЛАРХАЛ	ii
ТОВЧ ХУРААНГУЙ	iii
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	iv
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	v
ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ	vi
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	vii
ОРШИЛ	1
Сэдэв сонгосон үндэслэл	1
Сэдвийн зорилго	2
Сэдвийн зорилт	2
Судлагдсан байдлын судалгаа	2
Сэдвийн шинэлэг тал	5
Судалгааны арга зүй	5
I. БҮЛЭГ. ЗАХИРГААНЫ ГЭРЭЭНИЙ ТУХАЙ ОЙЛГОЛТ	6
1.1 Захиргааны гэрээний үүсэл, түүхэн хөгжил.....	6
1.2 Захиргааны гэрээний ойлголт	8
1.3 Захиргааны гэрээний төрөл.....	9
II. БҮЛЭГ. ЗАХИРГААНЫ ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ.....	12
2.1. Захиргааны Ерөнхий Хуулийн зохицуулалт	12
2.2 Захиргааны гэрээг хувийн эрх зүйн гэрээнээс ялгах нь /онолын үүднээс/	13
2.3 Захиргааны гэрээг захиргааны актаас ялгах нь	15
2.4. ЗГ-нд ИХ-ийн гэрээний суурь зохицуулалтыг нөхөн тохируулж хэрэглэх үндэслэл	17

2.5. ЗГ-нд ИХ-ийн гэрээний заалтыг нөхөн хэрэглэхийг хориглох буюу хязгаарлах нөхцөлүүд.....	19
2.6. ЗГ-нд ИХ-ийг нөхөн тохируулж хэрэглэж болох тохиолдлууд	20
III. БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ХЭСЭГ.....	26
3.1. Шүүхийн шийдвэрийн тоон үзүүлэлт	26
3.2. Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ	27
3.3. Захиргааны гэрээнд дүн шинжилгээ хийх нь, ярилцлагын арга.....	36
3.4. ЗГ-д ИХ-ийн зохицуулалтыг нөхөн тохируулж хэрэглэх талаар гадаад орнуудын харьцуулсан судалгаа.....	41
ДҮГНЭЛТ	47
САНАЛ, ЗӨВЛӨМЖ	49
НОМ ЗҮЙ.....	51

МЭДЭГДЭЛ

СЭЗИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан Б.Учрал миний бие энэхүү судалгааны бүтээлийг өөрөө хийж гүйцэтгэснийг баталж байна. Энэхүү судалгааны бүтээлийг СЭЗИС-ийн Хууль зүйн сургуулийн өмч болгож номын санд байршуулан нийтэд нээлттэй байлган нийтийн хүртээл болгуулахыг уг мэдэгдлээр дамжуулан хүлээн зөвшөөрч байна.

Нэр : Баярболд овогтой Учрал

Гарын үсэг :

Огноо :

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааны бүтээлийг гүйцэтгэлтэй, амжилттай хийж гүйцэтгэхэд өөрийн туршлага, мэдлэг болон судалгааны ажлыг маань чиглүүлэн, зөвлөгөө өгч ажилласан эрхэм удирдагч С.Батхүлэг багшдаа гүн талархал илэрхийлье. Мөн судалгааны ажлын явцад мэргэжлийн ур чадвар, үнэтэй зөвлөгөө, шүүмжээрээ намайг чиглүүлж, тэр тусмаа санал зөвлөмж боловсруулахад онцгой зөвлөгөө өгсөн шүүмжлэгч А.Билгүүн багшдаа болон Хууль зүйн сургуулийн нийт багш нартаа талархал дэвшүүлье. Мөн оюутан байх цаг хугацаанд найз нөхөд болсон найзууддаа мөн ангийнхандаа хамгийн сүүлд үргэлж дэмжиж, урам өгч, охиндоо итгэдэг гэр бүлийнхэндээ талархал илэрхийлье.

ТОВЧ ХУРААНГУЙ

Энэхүү дипломын ажил нь удиртгал хэсэг болон үндсэн онол, сэдвийн гол үндэслэл, судалгаа, дүгнэлт, санал зөвлөмжийн хэсгээс бүрдэнэ. Нэгдүгээр бүлэгт захиргааны гэрээний үүсэл, түүхэн хөгжил, түүний ойлголт болон бусад захиргааны үйл ажиллагаа дахь хэлбэрүүдээс ялгагдах онцлог, түүний төрлүүдийн талаар эрдэмтэн, судлаачдын өгүүлсэн өгүүлэл, эрдэм, шинжилгээний ажил, ном, сурах бичгээс судлан өөрийн дүгнэлтийг боловсруулсан. Хоёрдугаар бүлэгт, захиргааны гэрээний шинж, онцлогийг онолын болон ЗЕХ-д заасан байдал болон шинэчилсэн найруулгаас өмнө болон дараа түүнийг хэрэглэх харилцаануудын төрөл хэрхэн багассан талаар судалсан болно. Иргэний эрх зүй дэх гэрээний ойлголтоос яг ямар шинжээрээ ялгагдах тухай хараахан нэгдсэн бус байгаа хэдий ч онолын судалгааг хийж, захиргааны акттай харьцуулан ялгаатай шинжийг судлан харьцуулан дүгнэсэн болно. Түүнчлэн захиргааны гэрээнд иргэний хуулийн зохицуулалтыг нөхөн хэрэглэх хэрэгцээ шаардлага, үндэслэлийг судалсан, Гуравдугаар бүлэгт, практикт байгуулсан захиргааны гэрээний аль хэсэгт захиргааны хэм хэмжээ, аль хэсэгт нь иргэний хуулийн зохицуулалт хэрэглэгдсэн зэрэг дээр дүн шинжилгээ хийж, мөн түүнчлэн шүүхийн тоон үзүүлэлт болон иргэний хуулийн гэрээний суурь зохицуулалтыг нөхөн хэрэглэсэн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж, мөн гадаад улсын эрх зүйн зохицуулалт, ойлголттой харьцуулсан судалгааг хийсэн.

Түлхүүр үгс : *Нийтийн эрх зүйн гэрээ, захиргааны гэрээ, иргэний гэрээ, иргэний хуулийн гэрээний суурь зохицуулалт, нийтийн эрх зүйн зарчимд уялдуулах, нөхөн тохируулж хэрэглэх*

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

<i>Хүснэгт I-1. Захиргааны гэрээ нь Монгол Улсын эрх зүйд хөгжсөн түүхэн үйл явц.....</i>	<i>7</i>
<i>Хүснэгт II-1 ЗЕХ-д нэмэлт өөрчлөлт орохоос өмнө болон орсны дараах ялгаа.....</i>	<i>12</i>
<i>Хүснэгт II-2. Захиргааны гэрээ болон захиргааны актын ялгаатай болон нийтлэг тал....</i>	<i>15</i>
<i>Хүснэгт II-3. Захиргааны гэрээ болон захиргааны актын үндсэн шинж.....</i>	<i>16</i>
<i>Хүснэгт III-1. Шүүхийн шийдвэр №1.....</i>	<i>27</i>
<i>Хүснэгт III-2. Шүүхийн шийдвэр №2.....</i>	<i>31</i>
<i>Хүснэгт III-3. Шүүхийн шийдвэр №3 :.....</i>	<i>33</i>
<i>Хүснэгт III-4. Шүүхийн шийдвэр №4 :.....</i>	<i>35</i>
<i>Хүснэгт III-5. Захиргааны гэрээнд иргэний хуулийн зохицуулалтыг нөхөн хэрэглэснийг тогтоох.....</i>	<i>38</i>
<i>Хүснэгт III-6. Захиргааны гэрээнд дүн шинжилгээ хийсэн нь.....</i>	<i>39</i>
<i>Хүснэгт III-7. Захиргааны гэрээнд дүн шинжилгээ хийсэн нь.....</i>	<i>40</i>
<i>Хүснэгт III-8. ХБНГУ-ын хуульд захиргааны гэрээнд иргэний хуулийн зохицуулалтыг нөхөн хэрэглэх талаар хуульчилсан тухайд.....</i>	<i>41</i>
<i>Хүснэгт III-9. Шүүхийн шийдвэр №5.....</i>	<i>43</i>

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Захиргааны хэргийн Улсын дээд шүүхийн тогтоолд Захиргааны гэрээний маргааны төрөл тус бүр дэх эзлэх хэмжээг харуулав.....	26
Зураг 2. Захиргааны хэргийн Улсын дээд шүүхийн тогтоолд Захиргааны гэрээний маргааны төрөл тус бүр дэх эзлэх хэмжээг харуулав.....	27
Зураг 3. Гэрээ байгуулсан төрийн байгууллага	36
Зураг 4. Гэрээний төрөл.....	37

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

<i>Хавсралт А</i>	54
-------------------------	----

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЗЕХ	Захиргааны Ерөнхий Хууль
ЗХШХШТХ	Захиргааны Хэрэг Шүүхэд Хянан Шийдвэрлэх тухай хууль
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
УИХ	Улсын Их Хурал
ИХ	Иргэний хууль
ХДШ	Холбооны дээд шүүх
ВGH	Bundesgerichtsof

ОРШИЛ

Сэдэв сонгосон үндэслэл

Захиргааны гэрээ нь төрийн засаглалын нэг хэлбэр болох гүйцэтгэх эрх мэдлийн хэрэгжүүлж буй нэгэн хэлбэр юм. Учир нь гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч болох ЗЕХ-ийн 5 дугаар бүлэгт заагдсан захиргааны чиг үүргийг хэрэгжүүлэгч гурван хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг байна. Үүнээс үйл ажиллагааны нэг хэлбэр болох захиргааны гэрээ нь ЗЕХ-ийн 11.1.2 дахь хэсэгт хуульчлагдсан байна. Захиргааны гэрээ ЗЕХ-д заагдсан бусад хоёр хэлбэрээс ялгаатай тал нь иргэд, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж байгаагаараа онцлогтой. Үүнтэй холбогдуулан иргэд, хуулийн этгээдтэй байгуулсан захиргааны гэрээнд ЗЕХ-ийн тавдугаар бүлэгт заагдсанаас гадна ИХ-д заагдсан “*гэрээний суурь зохицуулалт нэгэн адил үйлчилнэ*”¹ гэж заасны дагуу ЗЕХ-ийн 58.1-т заасан иргэний хуулийн зохицуулалтыг нөхөн хэрэглэх талаарх тулгамдсан асуудал гарч ирдэг байна. Эдгээрээс нэг жишээг дурдвал, талууд нь захиргааны гэрээ байгуулан захиргааны гэрээний дагуу хүлээсэн үүргээ харилцан тохиролцож болох хэлбэрээр зарим заалтыг оруулсан бол заримдаа шууд санал өгсөн ба үүнийг нь нөгөө талын хүсэл зоригоос хамаарахгүйгээр зөвхөн биелүүлэх захирах захирагдах шинж мөн адил орсон байдаг. Харин гэрээний талууд нь уг гэрээний заалтыг буруу ойлгон, гэрээний эрх чөлөөний онолын дагуу хэрэглэх нь зүйтэй гэж үзсэнээс гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх асуудал тулгардаг. Мөн түүнчлэн өөр жишээг дурдвал, талууд нь сургуулийн барилгын ажлыг хийж гүйцэтгэх ёстой байсан ба талуудын ажлын гүйцэтгэлийн талаар шаардахдаа шүүхээс ИХ-ийн 343 дугаар зүйлийн холбогдох заалтуудыг нөхөн хэрэглэх нь зүйтэй хэмээн шийдвэрлэсэн байдаг зэргээс үзвэл практикт нөхөн хэрэглэх талаарх маргаан элбэг байгааг илтгэж байна. Иймд энэхүү төгсөлтийн ажлын дагуу гүнзгийрүүлэн судлах хөшүүрэг болсон. Мөн түүнчлэн миний хувийн зорилго нь өмгөөлөгч болж хэрэг маргаанд үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг хамгаалах чадварт суралцах юм. Эрх зүйн мэргэжлийн хүрээнд дадлагаа өмгөөллийн фирмд хийсэн ба энэ талаарх сэдэв сонирхолтой санагдсан тул уг төгсөлтийн ажлаараа илүү гүнзгийрүүлэн судлах нь цаашид уг хэрэг маргаанаар мэргэшин оролцох чадвар эзэмшихийг зорьсон болно.

¹ Захиргааны ерөнхий хууль (2015)-ийн 58 дугаар зүйлийн 58.1 дэх хэсэг

Сэдвийн зорилго

Захиргааны гэрээ нь өөрөө шинэ ойлголт буюу ЗЕХ-д хуульчлагдсанаас хойш багахан хугацааг өнгөрүүлж байгаа иймд уг гэрээний бүхий л харилцаа зохицуулалт нь ЗЕХ болон салбар хуулиудад бүрэн тусгагдан зохицуулагдсан гэвэл үйгүй байдаг үүнээс урган гарч ирэх асуудал нь ИХ-ийг нөхөн тохируулах зөв тохиолдлуудыг нь тодорхой болгох юм.

Сэдвийн зорилт

1. Захиргааны гэрээний ойлголт түүний түүхэн дэх хөгжлийн талаар судлах,
2. Захиргааны гэрээг хуульд хэрхэн тусгасан уг зохицуулалтыг задлан шинэчилсэн найруулгатай харьцуулалт хийх,
3. Хуульд заагдсан ерөнхий зохицуулалтыг задлан эрдэм шинжилгээ болон бусад судалгааны ажлуудыг судлан яг ямар тохиолдолд ингэж нөхөн хэрэглэх нь зүйтэй талаар үнэлэлт дүгнэлт өгөхөөр судалгаа хийх,
4. Практик дээр байгуулсан захиргааны гэрээний аль хэсэгт захиргааны хэм хэмжээ, аль хэсэгт нь иргэний хууль хэрэглэгдэх талаар дүн шинжилгээг хийх
5. Ярилцлагын аргаар бодит байгуулагдаж буй захиргааны гэрээнд иргэний хуулийг нөхөн тохируулахад тулгамдаж буй асуудлыг тодорхойлох
6. Гадаад улсын хуулийн зохицуулалттай харьцуулан кейсийг судлах

Судлагдсан байдлын судалгаа

1. **“Нийтийн эрх зүйн дэх зохицуулалтын арга: захиргааны гэрээ”. Ц.Цогт., 2007 он**

Товч хураангуй : Гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд захиргааны гэрээ нь захиргааны байгууллага нь тодорхой хуульд заасан хэм хэмжээнд үндэслэн иргэд, хуулийн этгээдтэй байгуулж буй баримт бичиг буюу уг өгүүлэлд дурдсанаар хамтын ажиллагаа олох талаар өгүүлсэн байдаг

2. **“Захиргааны гэрээ, түүний эрх зүйн зохицуулалтын онцлог”.** Б.Сүндэрьяа., 2017 **он**

Товч хураангуй : Энэхүү өгүүлэлд захиргааны гэрээний шинж, онцлог болон голчлон ЗЕХ-ийн шинэчилсэн найруулгаас өмнөх хуульд заасан байсан концессын харилцаан дахь захиргааны гэрээний талаар нарийвчлан судалсан судалгааг хийсэн байсан.

3. **“Нийтийн эрх зүй дэх захиргааны гэрээ: хувийн эрх зүйн гэрээнээс ялгагдах онцлог, шүүхийн хяналт”, Ц.Цогт., 2007 он**

Товч хураангуй : Гэрээний агуулга, зорилгоос хамааран хувийн эрх зүйн гэрээнд хамаарагдах уу? эсвэл нийтийн тэр дотроо захиргааны эрх зүй дэх захиргааны гэрээг тэдгээрийн онцлог шинжээр нь зааглан ялгахад уг судалгааны ажил хийгдсэн.

4. **“Захиргааны гэрээнд иргэний хуулийн зохицуулалтыг нөхөн тохируулж хэрэглэх асуудал”, Т.Мөнх-Эрдэнэ., 2016 он**

Товч хураангуй : Захиргааны гэрээг хэрхэн нөхөн тохируулах гэдгийг ЗЕХ-д ерөнхийлсөн байдлаар хуульчилж өгсөн байдаг. Энэхүү бүтээлээр ИХ-ийг нөхөн хэрэглэх асуудлыг онолын, хууль хэрэглээний түвшинд хөндсөн байдаг байна. Мөн хоёрдогч шинж гэх ойлголтыг тэрээр өөрийн өгүүлэлд судлаачийн зүгээс тайлбарласан байдаг.

5. **“Захиргааны эрх зүйн гэрээ захиргааны эрх зүйн эх сурвалж болох нь”., М.Долгорсүрэн., 2015 он**

Товч хураангуй : Эрдэм шинжилгээний өгүүлэлээр захиргааны гэрээ гэж юу вэ? тэдгээрийн төрлүүдийн талаар гүнзгийрүүлэн судлан, хэрхэн хэрэглэгдэх үндэс суурийг олох талаар судалгааг хийсэн.

6. **Захиргааны гэрээ: Концессын гэрээ буюу түүнээс үүсэх маргааныг хянан шийдвэрлэх харьяаллын асуудал., Д.Сүнжид., 2016 он**

Товч хураангуй : Концессын гэрээ нь өөрөө иргэний эрх зүйн гэрээний шинжийг агуулж байгаа юм биш үү? тэгш эрхийн үндсэн дээр хийгдэж байгаа юм биш үү? иймд захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлүүлж буй нь өөрөө маргаан дагуулж байгаа ба үүнд хэргийн харьяаллын асуудлыг шүүхийн шийдвэрт хамааруулан дүн шинжилгээ хийсэн байдаг.

**7. “Иргэний ба захиргааны гэрээний харилцан хамаарал, ялгагдах онцлог” .,
Магистрын зэрэг горилсон бүтээл., О. Вандандорж., 2009 он**

Товч хураангуй : Иргэний гэрээ болон захиргааны гэрээний тус бүрийн онцлог шинжүүдийг ашиглан хэрхэн ялган таних мөн түүнчлэн тэдгээрийн төсөөтэй байдлыг судлан, дүгнэн бичсэн байдаг.

8. “Захиргааны гэрээний эрх зүйн зохицуулалтыг төлөвшүүлэх нь /харьцуулсан судалгаа/” ., Докторын зэрэг горилсон бүтээл., П. Одгэрэл ., 2006 он

Товч хураангуй : Энэхүү бүтээл өдгөө түүний гаргасан Захиргааны эрх зүйн ерөнхий анги гэх бүтээлд орсон байдаг. Энэхүү судалгааны ажлаараа захиргааны гэрээний онцлог, төрөл, шинж болон иргэний эрх зүйн гэрээнээс ялган таних, Эх газрын эрх зүйн бүлийн ХБНГУ, Франц, Англи саксоны эрх зүйн бүл, Социалист эрх зүйн бүл зэрэгтэй харьцуулан судалгаа хийсэн байдаг.

9. “Захиргааны гэрээний эрх зүйн зохицуулалт, үйл ажиллагааны журмыг боловсронгуй болгох зарим асуудал” /Бакалавр/-СЭЗИС., Т. Гантөмөр., 2021 он

Товч хураангуй : Энэхүү бакалаврын ажилд Захиргааны гэрээний ойлголт болон хуульд хэрхэн тусгагдсан хэрхэн хэрэгжих хэрэгтэй юуг баримталж гэрээг хэрхэн байгуулах талаар судалсан онцлог бүтээл юм.

10. “Захиргааны гэрээний онцлог ба түүний иргэний хуулийн зохицуулалтыг нөхөн тохируулж хэрэглэх асуудлыг судлах нь” /Бакалавр/-СЭЗИС., Н. Сарангоо., 2022 он

Товч хураангуй : Иргэний гэрээний зохицуулалтыг нөхөн тохируулж болох, хязгаарлах талаарх шүүхийн шийдвэрийн хүрээнд дэлгэрүүлэн судалсан байдаг.

Сэдвийн шинэлэг тал

Энэхүү төгсөлтийн ажлын дагуу практик дээр хийгдсэн бодит гэрээнд дүн шинжилгээ хийх, анхан, давж заалдах, улсын дээд шатны шүүхийн буюу хяналтын шатны тогтоолоор хэрхэн шийдвэрлэж буй талаарх судалгаа ба гадаад орны эрх зүйд хэрхэн үздэг онолын ойлголт, хууль тогтоомжид хэрхэн тусгагдсан талаарх харьцуулсан судалгааг хийсэн. Мөн түүнчлэн захиргааны гэрээг байгуулдаг эрх бүхий албан тушаалтантай ярилцлага хийж бодит тулгамдаж буй асуудлыг тогтоосон нь уг ажлын шинэлэг тал нь юм.

Судалгааны арга зүй

1. Судалгааны аргыг сонгосон үндэслэл : Монгол улс нь эх газрын эрх зүйн бүлд хамаардаг ба ижил эрх зүйн бүлийн улс орнуудын хуулийн заалттай харьцуулан судалгаа хийж мөн жишгийн эрх зүйн кейстэй харьцуулсан судалгаа хийсэн болно.
2. Баримт бичгийн судалгааны аргаар хууль болон ном, сурах бичиг, эрдэм шинжилгээний өгүүлэл холбогдох бусад эх сурвалжуудаас судалгаа хийж дүгнэсэн.
3. Мөн түүнчлэн тохиолдол шинжлэх судалгааны аргаар шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж, харьцуулсан судалгааны аргаар захиргааны гэрээ гэх ойлголтыг харьцуулан судалсан.
4. Ярилцлагын аргаар захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтантай ярилцлага хийж практикт байгуулагдаж буй гэрээтэй холбоотой асуудлыг тодорхойлох

I. БҮЛЭГ. ЗАХИРГААНЫ ГЭРЭЭНИЙ ТУХАЙГ ОЙЛГОЛТ

1.1 Захиргааны гэрээний үүсэл, түүхэн хөгжил

Захиргааны эрх зүйн дэлхийн улс орнуудад тодорхой нэг байгууллага эсвэл хууль тогтоомжийг баталснаар түүний дагуу хөгжлийн замдаа орсон байдаг. Үүнээс “захиргааны эрх зүйн шинжлэх ухаанд хамгийн анх захиргааны гэрээ гэх ойлголт нь XIX зууны 2 дахь хагаст үүссэн гэдэг. Захиргааны гэрээг түүхэн хүрээнд авч үзвэл анх XX зууны эхэн үед мужуудын иргэний хуульд нэвтрүүлсэн бөгөөд энэ нь Францад эхэлсэн байна”.² (Batalli)

Захиргааны гэрээний түүхэн цаг үед хүлээн зөвшөөрөгдөж чаддаггүй байсан тухайд:

Захиргааны гэрээ нь түүхэн хөгжлийн явцад хүлээн зөвшөөрөгдөхгүй байсан. Энэ нь түүний онцлог шинж болох захирах, захирагдах харилцаа нь өөрөө захиргааны эрх зүйн үндсэн шинж байтал хэрхэн яаж иргэний эрх зүй дэх тэгш эрхийн үндсэн дээр байгуулдаг гэрээг байгуулж чадах юм бэ? Онолын хувьд зөрчилдөөн үүсгэж буй учир захиргааны гэрээ байгуулах боломжгүй гэх ойлголтыг төрүүлж байсан нь түүнийг хүлээн зөвшөөрөгдөхөд хүндрэл саад болсон байна. Мөн түүнчлэн захиргааны үйлдэн гаргах түүний үйл ажиллагааны хэлбэрүүд болох захиргааны акт, захиргааны хэм хэмжээ нь зөвхөн төрийн хүсэл зоригийн үүднээс байдаг буюу нэг талын байдгаараа онцлогтой энэ нь дээрх онцлог шинж болох захирах, захирагдахтай холбогддог иймд үүнээс өөрөөр захиргааны гэрээ гэх ойлголтыг тэгш эрхийн бус гэсэн ойлголт байсан нь хүлээн зөвшөөрөгдөж чадахгүй байсан гол шалтгаан байв.

Гэвч захиргааны гэрээг Францын гүн ухаантан Жан Жак Руссогийн “Аливаа хүн ижил заяатнаа захирах эрхгүй. Хүмүүс хоорондын харилцааны хууль ёсны эрх мэдлийн үндэс нь гагцхүү зөвшилцөл”³ (Руссо, 1972) гэсэн алдарт нийгмийн гэрээний үндэслэгчийн уг онолын дагуу мөн тайлбарладаг байна. Үүнээс түүхэн хөгжлийн явцад төр нь дан ганцхан гүйцэтгэх эрх мэдлээ захиргаадлын аргаар нэг талын буюу төрийн хүсэл зоригийн үндсэн дээр суурилан нэг талд бий эрх олгож нөгөө талд үүрэг бий болгодог захиргааны акт,

2

Ahmet Imami & Mirlinda Batalli, The Role of Administrative contracts in the field of public administration, Ajee journal, 394

³ Жан Жак Руссо, *Нийгмийн гэрээ*, (орч Цэндийн Батбуян), 2016, 38 дахь тал

захиргааны хэм хэмжээний актаас гадна өөр нэг түүний хэрэгжүүлэх хэлбэр захиргааны гэрээ нь нэн шаардлагатай юм байна гэдгийг хүлээн зөвшөөрсөн.

Захиргааны гэрээний шаардлага нь тухайн улс орны хөгжлийг хурдасгах, ард иргэдийн сайн, сайхны төлөө буюу нийтийн эрх, ашиг сонирхлын үүднээс төр нь иргэд, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж улс орны дэд бүтэц, бүтээн байгуулалт зэргийг хэрэгжүүлэх хамтын ажиллагаа болох ач холбогдолтой байсанд оршдог.

Монгол улсын түүхэн дэх захиргааны гэрээний үүсэл, хөгжил

Монгол улсын хувьд “Захиргааны гэрээ” гэх ойлголт нь дараах хөгжлийн үйл явцад хэрхэн тусгагдсан байсныг авч үзэх нь зүйтэй.

Хүснэгт I-1. Захиргааны гэрээ нь Монгол Улсын эрх зүйд хөгжссөн түүхэн үйл явц

1992 оноос өмнөх үе	1992-2015 оны хооронд	2015 оноос хойших үе
Социалист буюу Зөвлөлтийн эрх зүйн бүлд захиргааны гэрээ гэх ойлголт байдаггүй байсан. Зөвхөн захиргааны актыг захиргааны үйл ажиллагааны хэлбэр гэдгээс захирах захирагдах харилцаанд гэрээ гэх ойлголтыг хүлээн зөвшөөрдөггүй байсан.	1992 оны Үндсэн хууль батлагдаж захиргааны гэрээ практикт хэрэглэгдэх болсон. Захиргааны гэрээ батлагдсанаараа улсын хөгжил дэвшил бүтээн байгуулалтыг хувийн хэвшлээр хийлгэх үндэс болсон. Хамтын ажиллагаа явуулахаар төр нь хувийн хэвшлүүдтэй гэрээ байгуулах эрх зүйн үндэс болсон.	2015 онд шинээр батлагдсан Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар бүлэгт бие даасан үйл ажиллагааны хэлбэр болгон хуульчилсан. Ингэснээр захиргааны гэрээний төрлүүдийг тусгаснаар хуульд заасан уг төрлүүдийн дагуу хамтын ажиллагаа хийгдэж эхэлсэн байна. ⁴

Эх сурвалж : Захиргааны эрх зүйн ерөнхий анги, П.Одгэрэл, 2016 он (р.235-236)

⁴ Пүрэвдолгорын Одгэрэл, Захиргааны эрх зүйн ерөнхий анги, (2016), 235-236 дахь тал

1.2 Захиргааны гэрээний ойлголт

“Захиргааны гэрээ нь нийтийн эрх зүйн гэрээний төрөлд хамаарахын зэрэгцээ захиргааны үйл ажиллагааны нэг хэлбэр болно”.⁵ (П.Одгэрэл, 2016). Нийтийн эрх зүйд захиргааны акт, захиргааны гэрээ, захиргааны хэм хэмжээ нь чухал ач холбогдолтой байдаг. Яагаад гэвэл эдгээр нь захиргааны байгууллагаас гаргах эрх зүйн баримт бичиг гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлж буй нэг хэлбэр болдог. Энэ нь захиргааны байгууллага нийтийн ашиг сонирхлын үүднээс иргэд, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж буй үйлдэл тул захиргааны хамтын ажиллагааны илэрхийлэл болдог байна. Үүнээс захиргааны гэрээ нь аливаа харилцааг үүсгэж, өөрчлөх, дуусгавар болгодог хууль зүйн факт гэж үзэх боломжтой байна.

“Сонгодог утгаараа “Захиргааны гэрээ” гэж нэрлэгдэх нь нийтийн захиргааны байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд явуулж буй үйл ажиллагааны хэлбэр болсон тэр гэрээ юм.”⁶ “Захиргааны гэрээний холбогдох ойлголтыг салбарын хуулиудад зохицуулсан байдаг”.⁷ “Захиргааны эрх зүйн эх сурвалж болох салбарын төрөлжсөн хуулиуд нь тухайн салбарынхаа мэргэжлийн онцлог бүхий нарийвчилсан зохицуулалтыг агуулдаг”.⁸

А. Гэрээний зохицуулалтыг тодорхойлон заасан тухай

Захиргааны гэрээ нь хэм хэмжээнд үндэслэх ёстой буюу түүний салбар хуулиудад гэрээ байгуулах талаар тусгайлан хуульчилж өгсөн байдаг. Үүнд нь хэрхэн гэрээг байгуулах талаар журмыг заасан ба гэрээний талууд болох захиргааны байгууллага гэх ЗЕХ-ийн 5.1 дэх хэсэгт заагдсан эрх бүхий этгээд болон түүнтэй гэрээ байгуулж буй иргэн, хуулийн этгээдийн эрх болон үүрэг хариуцлагыг дурдсан байдаг. мөн гэрээнд тавигдах тодорхой шаардлагууд, гэрээний хугацаа, хүчингүй болгох үндэслэл, үр дагавар, хамгийн сүүлд талуудын хооронд гэрээтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд маргаан шийдвэрлэх зэргийг хуульчилсан байдаг.

Б. Гэрээ байгуулах эрх олгосон тухай

⁵ Пүрэвдолгорын Одгэрэл, *Өмнөх эшлэл 4, 246 дахь тал.*

⁶ Цэндийн Цогт, “Нийтийн эрх зүй дэх захиргааны гэрээ хувийн эрх зүйн гэрээнээс ялгагдах онцлог, шүүхийн хяналт”, *Хууль дээдлэх ёс*, 2007, 4 дэх тал

⁷ Гочоогийн Банзрагч, “Эдийн засгийн захиргааны эрх зүй”, (Улаанбаатар хот, 2013), 122 дахь тал

⁸ Пүрэвдолгорын Одгэрэл, *Өмнөх эшлэл 4, 245 дахь тал*

Зарим салбар, ердийн хуулиудад дээрх тохиолдол шиг тодорхой гэрээнд шаардлагатай нөхцөлийн талаар тодорхой хуульчилж өгөөгүй байдаг байна. “Өөрөөр хэлбэл цогц зохицуулалтыг хийгээгүй буюу ерөнхий суурь зохицуулалтуудыг оруулсан байхыг ойлгоно. Үүнд: Ойн тухай хууль, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, Хог хаягдлын тухай хууль гэх мэт хамаарна.”⁹

В. Хуульд заасны бүрэн эрхийн хүрээнд захиргааны гэрээг байгуулж байгаа байдал

Гэрээ байгуулах эрх олгосон цөөхөн хэдэн заалтыг тусгасан байх бөгөөд тэрхүү зохицуулалт нь судалгаа шаардагдах тодорхой бус байхыг ойлгоно. Өөрөөр хэлбэл салбар хуулиудыг нарийвчлан судлах шаардлагатай буюу практикт байгуулагдаж буй гэрээнүүдтэй тус бүр танилцах хэрэгтэй.¹⁰

Үүний дагуу гуравдугаар бүлэг буюу судалгааны хэсэгт захиргааны бодит байгуулагдсан гэрээнд дүн шинжилгээ хийсэн байгаа.

Тухайлбал, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулиар Монгол Улсын Улаанбаатар хотын төв болох Сүхбаатарын талбайд иргэд нь жагсаал, цуглаан хийхээр төлөвлөсөн талаарх мэдэгдлийг уг хуульд заасны дагуу эрх бүхий этгээд буюу нийслэл дэх засаг даргадаа өгчээ мөн хуульд заасны дагуу засаг дарга нь хүлээн авснаасаа хойш ажлын 3 өдрийн дотор түүнийг бүртгэх талаар шийдвэр гарган хүлээн авч бүртгэсэн талаар бичгээр мэдэгддэг байна. Уг хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу жагсаал, цуглааныг зохион байгуулагч зохих үүрэг хүлээдэг бөгөөд энэхүү үүргийн биелэлтийг хангах зорилгоор нийслэлийн Засаг даргын тамгын газар жагсаал цуглаан зохион байгуулагчтай гэрээ байгуулж байна.¹¹

1.3 Захиргааны гэрээний төрөл

Захиргааны гэрээг дараах 3 агуулгаар ангилсан байна. Үүнд :

Зохицуулж буй салбараар : Захиргааны гэрээг ЗЕХ-ийн 52 дугаар зүйлийн 52.1-д заасны дагуу төрийн алба, боловсрол, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах болон бусад захиргааны эрх зүйн харилцаанд хэрэглэж болохоор хуульчилжээ. Үүнээс зөвхөн уг

⁹ Цэндийн Цогт, *Захиргааны хэргийн шүүх*, (Улаанбаатар хот, 2019), 195 дахь тал

¹⁰ *Мөн тэнд.195 дахь тал*

¹¹ НЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, “Монгол төрийн уламжлалыг сэргээх үндэсний хөдөлгөөн”-ий тэргүүнтэй 2018.04.11-ний өдөр байгуулсан “Жагсаал цуглаан бүртгэх тухай” гэрээ.

салбаруудад хамаарах бус өөр бусад захиргааны харилцаанд ч хэрэглэж болохоор хуульчилсан нь үүнээс илүү өргөн салбаруудад хамаарч болно гэсэн үг юм.

Зорилго, чиг үүргээр нь : Аж ахуйн харилцаан дахь бүтээн байгуулалтын, өмч хувьчлалын, захиргааны чиг үүргийг хамтран биелүүлэх гэх мэт¹²

Эрх зүйн шинжээр нь : Захиргааны актын оронд байгуулсан, мөн түүнчлэн түүний үйлчлэлийг гүйцээх байдлаар гэрээг байгуулдаг байна. Үүнээс гадна хууль зүйн факт буюу тодорхой харилцааг үүсгэхийн тулд зөвшөөрөл буюу эрхийг үүсгэсэн болон тухайн хүн, хуулийн этгээдэд үүрэг бий болгосон¹³ байдлаар ангилдаг байна.

¹² Пүрэвдолгорын Одгэрэл, *өмнөх эшлэл 4, 257* дахь тал.

¹³ *Мөн тэнд. 257* дахь тал

Бүлгийн дүгнэлт :

Энэхүү бүлгээр захиргааны гэрээний үүсэл хөгжил болон захиргааны гэрээний талаарх ойлголт түүний төрлүүдийн талаар судлах нь судлаачийн зүгээс миний тавьсан зорилго байсан.

Нэгдүгээр хэсэгт, захиргааны гэрээ гэх ойлголт түүхэн цагт хүлээн зөвшөөрөгдөх хүртэл урт зам туулсныг судалсан. Энэ нь захирах-захирагдах харилцаа нь захиргааны үндсэн шинж байснаас улбаалсан байдаг. Гэвч захиргааны гэрээ нь тухайн улсад бүтээн байгуулалт, дэд бүтцийг бий болгох том хөшүүрэг гэдгийг хөгжлийн явцад ойлгож түүнийг хүлээн зөвшөөрөх хандлага үүсэж цаашид албан ёсоор хуульчилсан байдаг. Мөн түүнчлэн Монгол улсад “захиргааны гэрээ” гэх ойлголт нь Монгол улсын Үндсэн хууль батлагдсанаас хойш практикт бий болж эхэлсэн байдаг ба 2015 онд түүнийг захиргааны үйл ажиллагаа дахь илрэн гарах нэгэн хэлбэр болгон хуульд зааснаар захиргааны гэрээний хөгжил хууль эрх зүйн орчинд хурдацтай хөгжиж ирсээр байна.

Хоёрдугаар хэсэгт, захиргааны гэрээ гэх ойлголтын талаар авч үзсэн. Захиргааны гэрээ нь захиргааны илрэн гарах нэгэн хэлбэр ба салбар хуулиудад захиргааны гэрээг байгуулах талаар тусгайлан хуульчилсан байдаг. Харин үүнээс дан ганц төрөлжсөн салбар хуулиас гадна практикт уг хуулиудад аливаа нэгэн асуудалд хэрэгжилтийг нь хянах чиг үүрэг бүхий этгээд нь уг чиг үүргийн хүрээнд гэрээ байгуулсан тохиолдол байдаг ба иймд практикт гэрээг ч мөн адил судлах хэрэгцээ шаардлага байдаг талаар энэхүү хэсэгт судалсан. Тухайн салбар хуулиар тухайн харилцаа нь ойн сантай холбоотой эсэх, төрийн болон орон нутгийн өмчийг худалдан худалдан авахтай холбоотой гэх мэтээр тусгайлсан зохицуулалтыг мөн хуульчилж өгсөн байдаг талаар судалсан болно.

Гуравдугаар хэсэгт, захиргааны гэрээний төрлийн ангиллыг 3 төрөл байдаг талаар судалсан. Ингэж ангилахдаа ЗЕХ-ийн 52.1 дэх хэсэгт заагдсан захиргааны гэрээг байгуулах харилцаа бүрээр салбар харилцаа болгон хуульчилсан байдаг ба уг харилцаа тус бүрээр нь салбарын гэж ангилах боломжтой байна. Үүнээс гадна чиг үүргийн хувьд өмч хувьчлал, захиргааны байгууллага нь өөрийн чиг үүргийг бусад этгээдтэй хамтран хэрэгжүүлэх гэх байдлаар чиг үүргээр нь ангилдаг байна. Хамгийн сүүлийн ангилал нь гэрээний шинжээр ангилдаг байна. Гэрээгээр эрх олгосон, үүрэг бий болгож буй эсэхээс хамааруулан мөн түүний актыг нөхөн гүйцээсэн буюу актад тулгуурлан гэрээг байгуулсан гэх мэтийг үндэслэн төрлүүдийг тодорхойлдог байна.

II. БҮЛЭГ. ЗАХИРГААНЫ ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

2.1. Захиргааны Ерөнхий Хуулийн зохицуулалт

ЗЕХ-ийн 5 дахь хэсэг буюу бүлэгт захиргааны гэрээний зохицуулалтыг хийсэн байдаг ба энэ хуулийн 52.1 дэх хэсэгт заасан байдаг. Ингэж заахдаа гэрээг хэрэглэх харилцааг төрөлжүүлэн хуульчилсан байдаг.

Хүснэгт II-1 ЗЕХ-д нэмэлт өөрчлөлт орохоос өмнө болон орсны дараах ялгаа

Захиргааны ерөнхий хууль /Нэмэлт өөрчлөлт орсны дараа/	Захиргааны ерөнхий хууль /Нэмэлт өөрчлөлт орохоос өмнө/
52.2.3. төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслөөр хэрэгжүүлэхээс бусад ... харилцаанд; ¹⁴	52.2.3. дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээг бий болгох, тогтвортой ашиглахтай холбогдсон харилцаанд; 52.2.4. концессын харилцаанд; ¹⁵

ЗЕХ-ийн 52 дугаар зүйлд заасан “концесс” гэх агуулгыг бүрэн хассан ба “төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслөөс бусад” гэх агуулгыг оруулж нэмж өөрчилсөн. Учир нь Концессын тухай хуулийг 2023 оны 12 сарын 31-ний өдөр хүчингүй болгосон ба үүний оронд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиар уг хуулиар зохицуулдаг байсан харилцааг зохицуулж шинэ хууль баталсантай холбогдуулан хүчингүй болсон байдаг. Мөн түүнчлэн уг дэд бүтцүүд болох төмөр зам, барилга байгууламж болон эрүүл мэнд болон бусад нийгэмд үзүүлэх үйлчилгээг үзүүлэх эдгээрийг тогтвортой ашиглах талаар уг шинээр батлагдсан хуулиар зохицуулах болсон ба энэ хуульд зааснаар “түншлэлийн гэрээ” нь тэгш эрхийн зарчимд тулгуурласан гэх агуулгаараа захиргааны эрх зүйн гэрээ биш харин иргэний эрх зүйн гэрээ гэж хуульчилснаараа ЗЕХ-д хамаарахгүйг тусгасан байдаг. Энэ нь уг гэрээний шинж нь иргэний эрх зүйн гэрээний шинжийг агуулж байгаа эсэхээс хамааран ийнхүү хуульчилжээ.

¹⁴ ЗЕХ-ийн 52 дугаар зүйлийн 52.2.3 дахь хэсэг /Шинэчилсэн найруулга/

¹⁵ ЗЕХ-ийн 52 дугаар зүйлийн 52.2.3, 52.2.4 дэх хэсэг

2.2 Захиргааны гэрээг хувийн эрх зүйн гэрээнээс ялгах нь /онолын үүднээс/

Захиргааны эрх зүйн гэрээг ИХ-д заагдсан гэрээнүүдээс ялгахдаа дараах арга зүйг ашиглан захиргааны гэрээний онцлог, ялгаатай шинжээр нь ялгах дараах 4 онол үзэл баримтлал байдаг. Үүнд,

Нэгдүгээрт, тухайн гэрээгээр хэний ашиг сонирхол хөндөгдөж байгаа субьектээс нь хамааруулан мөн түүний үр дагавар нь нийтийн ашиг сонирхол эсвэл хувийн ашиг сонирхлын алийг хөндөж байгаагаас нь хамааруулан ялгах боломжтой. Захиргааны эрх зүйн гол шинж болох захирах харилцаан дээр тулгуурладаг харин иргэний эрх зүйн гэрээний харилцаанд субьектүүдийн зэрэгцээ буюу ижил тэгш эрхтэй үед л байгуулагддаг түүнийг байгуулж буй этгээд ямар субьект гэдгээс үл хамаардаг.¹⁶ (САН, Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар, 2017 он)

Субьектийн онол (Subjektstheorie): Тэгш эрхтэй иргэд хоорондоо захиргааны гэрээг байгуулж болдог. Тухайлбал, гэрээг байгуулж буй этгээд буюу гэрээгээр эрх, үүрэг хүлээж байгаа нэг талын этгээд заавал захиргааны үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага байх албагүй ба захиргааны гэрээ нь иргэний эрх зүйн хоёр субьектүүдийн хооронд байгуулагдах боломжтой хэмээн үздэг.¹⁷ (САН, Монгол улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар, 2017 он)

Хоёрдугаарт, тухайн гэрээний зүйл буюу талуудын хэлэлцэн тохиролцсон гол зүйл нь юу вэ гэдгээс хамааруулан ялгах.

Гэрээний зүйлийн онол (Gegenstandstherorie): Гэрээний зүйл гэдэг нь гэрээг байгуулж буй талуудын хүсэл зоригоо илэрхийлэн байгуулж буй гэрээний объект юм. Мөн уг гэрээгээр үүсэж буй үр дагавар нь аль эрх зүйд хамаарч байгаагаас нь хамааруулан ялгах юм. Дэлгэрүүлж хэлбэл, тодорхой нэг эрх зүйн харилцааг үүсгэж, өөрчлөх, дуусгавар болгож буй хууль зүйн факт нь захиргааны эрх зүйд хамаарагдаж байгаа эсэхээс хамаарна.

Гуравдугаарт, талуудын хооронд байгуулагдаж буй гэрээнээс хэний ямар эрх ашиг хөндөгдөх вэ? гэх асуултын хариултаас хамаарч нийтийн болон хувийн эрх зүйн гэрээний аль гэдгийг тодорхойлох боломжтой байна.

¹⁶ Ханнс-Зайделийн сан, *Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар*, (2017) , 240 дэх тал

¹⁷ Ханнс-Зайделийн сан, *өмнөх эшлэл 16, 240-241 дэх тал*

Ашиг сонирхлын онол (Interessentheorie): Уг онолын хувьд гэрээ нь өөрөө субъектүүдийн хүсэл зориг нь нийтийн ашиг сонирхол дээр тулгуурлан хийгдсэн байх юм бол нийтийн эрх зүйн гэрээ гэж үздэг. Харин гэрээгээр талуудын ашиг сонирхол үүний эсрэгээрээ хувийн эрх зүйн хэм хэмжээгээр илэрхийлэгдэх тохиолдолд хувийн эрх зүйн гэрээ гэж ялгагдаг байна.

Дөрөвдүгээрт, гэрээнд аль нэг тал нь ямар эрх, үүрэг хүлээх эрх зүйн хэм хэмжээнд хэрхэн тусгагдсан байхаас шалтгаалан гэрээг ялгагдаг.

Шатлалын онол (Zuordnungstheorie): Энэ нь эрх зүйн хэм хэмжээгээр авч үзвэл, хувийн эрх зүйн хэм хэмжээ нь тодорхой нэг албан тушаалтан төрийн зүтгэлтэн байхаас үл хамааран бүх хүмүүст үйлчилдэг харин нийтийн эрх зүйн хэм хэмжээ нь шатлалын онолын дагуу зөвхөн төр, дээд захирах эрх бүхий этгээдэд үйлчилдэг байна.

Захиргааны гэрээг иргэний гэрээнээс ялгагдах онцлог шинж

1. **Хууль тогтоомжид тусгагдсан байдлаар нь:** Захиргааны гэрээг ЗЕХ-ийн 52 дугаар зүйлд бие даасан нэгэн захиргааны үйл ажиллагааны хэлбэр болгон хуульчилсан байна. Мөн түүнчлэн захиргааны хэм хэмжээнд үндэслэн байгуулагдах ёстой хууль зүйн факт юм.
2. **Гэрээний зорилго, агуулгаар нь:** Уг гэрээг байгуулах болсон талуудын хүсэл зоригийн нэгдэл нь хувийн биш харин нийтийн ашиг сонирхол байх ёстой. Мөн түүнчлэн гэрээ байгуулах талуудын заавал нэг нь захиргааны байгууллага, эрх бүхий албан тушаалтан байдаг ба эдгээр төрийн чиглэл, төлөвлөгөө, зорилтод үндэслэн үйл ажиллагааг явуулахаар гэрээг байгуулдаг гэж судлаачийн зүгээс үзэж байна.
3. **Гэрээний талууд гэрээний нөхцөлд нөлөөлөх байдлаар нь:** Гэрээнд нөлөөлөх байдал гэж талууд харилцан тохиролцож гэрээнд өөрчлөлт оруулах, хугацаа сунгах, төлбөрийн хэмжээг өөрчлөх гэх мэт зүйлсийг хамаардаг. Тэгтэл захиргааны гэрээний хувьд энэ нь хувийн эрх зүйн гэрээтэй харьцуулбал хамаагүй хязгаарлагдмал байдаг. Энэ нь түүний гэрээний нөхцөл нь хуульчлагдсан байх тул захиргааны гэрээний хэм хэмжээнд үндэслэх буюу “хууль дээдлэх зарчим”-ын үүднээс зөрчиж боломгүй зүйл байдаг. Иймд хаагдмал хэдий ч гэрээнд нөгөө талын саналыг хүлээн авч өөрчлөх боломж бий байдаг гэхдээ үүнийг зөвхөн захиргааны байгууллага, албан тушаалтан нь зөвшөөрсөн тохиолдолд үйлчилдэг байна.

4. *Маргаан шийдвэрлэхдээ аль хэм хэмжээн дэх журмаар шийдвэрлэгдэх эсэхээс хамааруулах* : Захиргааны гэрээнээс үүдэн гарсан түүнтэй холбогдсон хэрэг маргаан нь захиргааны хэм хэмжээнд заасан хянан шийдвэрлэх журмаар шийдвэрлэгддэг.¹⁸

2.3 Захиргааны гэрээг захиргааны актаас ялгах нь

Захиргааны гэрээ нь тодорхой нэг талаараа захиргааны акттай ижил зүйл байдаг боловч ялгаатай ойлголтууд юм. Уг хоёр зүйлийн “эрх зүйн гол ялгаа нь “гэрээ” гэх ойлголтоос урган гардаг”.¹⁹

Үүнээс гэрээг талууд нь харилцан зөвшилцдөг буюу дан ганц нэг талын хүсэл зоригийн үүднээс хийгддэггүй. Ялангуяа захиргааны актын хувьд авч үзвэл, тухайн актаар дамжуулан хэн нэгэнд үүрэг болгодог ба нөгөө талын хүсэл зориг үүнд огт хамааралгүй дангаар хийгддэг зүйл байна. Хэдий захиргааны гэрээгээр гэрээний ерөнхий байдлыг тулгасан мэт боловч зарим хэсэгт нь нөгөө талын хүсэл зоригийг илэрхийлсэн саналыг хүлээн зөвшөөрч тохиролцох нь гэрээ гэх ялгах хамгийн том зүйл гэдгийг харж болно. Мөн түүнчлэн ялгаатай болон төсөөтэй шинжүүдийг харьцуулан харуулах юм бол дараах байдалтай байна.

Хүснэгт II-2. *Захиргааны гэрээ болон захиргааны актын ялгаатай болон нийтлэг тал*

Ялгаатай тал	Нийтлэг тал
<ul style="list-style-type: none"> Нэг талын хүсэл зоригээр, эсхүл нэг тал санал гаргаж түүнийг хүлээн зөвшөөрөн харилцан тохиролцож байгаа эсэхээс хамааруулан ялгадаг. 	<ul style="list-style-type: none"> Аль аль нь тухайн зохицуулж буй харилцаа нь гадагш нөлөө бүхий байдгаараа нийтлэг байдаг.²⁰

Хүсэл зоригийн үүднээс ялгаатай гэж үзэхэд маргаан байдаг. Энэ нь зарим захиргааны акт нь тухайн тодорхой нэг тохиолдолд хаяглагдах этгээдийн саналыг буюу хүсэл зоригийг авсан хойно л хэрэгжих нөхцөл бүрддэг. Үүнийг гэхдээ зөвхөн тодорхой тохиолдолд л хамаарна гэдгийг анхаарах хэрэгтэй. Иймд гэрээний нэг тал санал гаргаж буй байдлаас өөр зүйл юм.

¹⁸ Ханнс-Зайделийн сан, *өмнөх эшлэл 16, 252 дахь тал*

¹⁹ Пүрэвдолгорын Одгэрэл, *өмнөх эшлэл 4, 254 дэх тал.*

²⁰ *Мөн тэнд. 254 дэх тал*

Хүснэгт II-3. Захиргааны гэрээ болон захиргааны актын үндсэн шинж

Захиргааны гэрээний үндсэн шинж	Захиргааны актын шинж
<p>1. Захиргааны байгууллага гаргасан : гэрээг байгуулж талын нэг нь захиргааны байгууллага байна. Гэрээ байгуулах субъектүүдийн хүрээнд дараах байдлаар ангилагддаг.</p> <ul style="list-style-type: none"> • Захиргааны байгууллага хоорондын • Захиргааны байгууллага нь иргэн, хуулийн этгээдтэй • Иргэд хоорондын 	<p>1.Захиргааны байгууллагаас гаргасан : ЗЕХ-ийн 5.1-т заасан захиргааны байгууллага нь нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргасныг хэлнэ. Үүнээс бусад этгээд шийдвэр гаргасан нь захиргааны акт гэж үзэх үндэслэлгүй юм.</p>
<p>2. Нийтийн эрх зүйн хүрээнд байх : гэрээний зохицуулж буй зүйл нь нийтийн тэр тусмаа захиргааны эрх зүйн хүрээнд байх ёстой. Гэвч уг нийтийн эрх зүй дэх гэрээ гэх ойлголтоос салгах хэрэгтэй учир нь захиргааны гэрээ нь зөвхөн нийтийн эрх зүйн гэрээний нэгэн төрөл учир анхаарах хэрэгтэй.</p>	<p>2.Тодорхой нэг тохиолдлыг зохицуулсан эсэх : тухайн захиргааны актаар байнга давтагдах шинжгүй буюу нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ бус харин зөвхөн ганц л асуудалд зориулан тодорхой нэг этгээдэд зориулан шийдвэр гаргасныг ойлгоно.</p>
<p>3. Гэрээ байгуулагдсан байх : эрх зүйн харилцааг үүсгэж, өөрчилж, дуусгавар болгох буюу хууль зүйн факт байх ёстой. Мөн гэрээ нь талуудын хүсэл зоригийн үндсэн дээр байгуулагдсан байна. Аливаа гэрээний нэгэн адил талууд нь эрх болон үүргийг уг гэрээгээр хүлээнэ.</p>	<p>3.Нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн : захиргааны акт нь зөвхөн нийтийн эрх зүйн хүрээнд гарах ёстой ба үүнээс хэрхэн ялган таних вэ? гэвэл захиргааны үйл ажиллагааны үр дүнд хэний ямар эрх, ашиг сонирхол хөндөгдөж аль салбар эрх зүйд хамаарч байгаагаар нийтийн эрх зүйн хүрээнд буй эсэхийг тогтооно.</p>
<p>4. Эрх зүйн хэм хэмжээнд нийцсэн байх : захиргааны гэрээ нь ЗЕХ-иас гадна</p>	<p>4.Гадагш чиглэсэн : Энэ нь байгууллагын дотоод хүрээнд бус харин бусад этгээдэд</p>

<p>салбар хуулиудаар зохицуулагддаг байна. Иймд эдгээр хуулиудыг зөрчсөн гэрээ хэлцэл хийхгүй байх ёстой. Энэ нь “хууль дээдлэх” зарчмыг хангаж буй хэрэг юм.</p>	<p>зориулж тэдэнд хамаатуулан эрх, үүрэг болгож буй тохиолдолд энэ нь гадагш чиглэсэн болно.</p>
	<p>5. Эрх зүйн шууд үр дагавар бий болгосон : захиргааны актын үр дүнд эерэг, сөрөг үр дагавар бий болгодог. Уг акт гарснаараа энэ хоёр үр дагаврын аль нэг үүсэх ёстой. Хэрэв үүсгэхгүй байвал энэ нь захиргааны акт биш болно.</p>
	<p>6. Захирамжилсан шийдвэр : ямар нэгэн зүйлийг хийхийг үүрэг болгосон, эсвэл зөвшөөрөл, эрх олгосон, мөн түүнчлэн хориглосон шийдвэр гаргах нь захирамжилсан шийдвэр юм.</p>

2.4. ЗГ-нд ИХ-ийн гэрээний суурь зохицуулалтыг нөхөн тохируулж хэрэглэх үндэслэл

ЗЕХ нь дангаараа нийтийн эрх зүй дэх нийтийн ашиг сонирхолтой холбоотой харилцаа болгоныг хуульчилж зохицуулсан байх боломжгүй байна. Мөн нийтийн харилцаа нь өргөн том хэмжээний харилцаа тул олон төрлийн салбар хуулиудаар зохицуулагддаг. Үүнээс захиргааны гэрээ гэх ойлголт нь ийнхүү гол хууль түүний төрөлжүүлсэн хуулиудаар хүртэл зохицуулагдсан хэдий ч гэрээ гэх ойлголт түүний үндэс суурь нь яахын аргагүй ИХ-иар зохицуулагддаг нь маргашгүй үнэн. Үүнээс дүгнэн үзвэл захиргааны гэрээг ЗЕХ-д хуульчлахдаа уг гэрээний бүхий л агуулга, харилцааны нарийн зүйлүүдийг хуульчлан зохицуулаагүй байна. Захиргааны гэрээг байгуулах үед эсвэл байгуулсны дараа гэрээнд иргэний эрх зүйн хэм хэмжээг нөхөн тохируулж хэрэглэх нь гэрээний суурь зохицуулалтыг нарийвчлан зохицуулсантай нягт холбоотой. Захиргааны гэрээнд иргэний хуулийн зохицуулалтыг нөхөн хэрэглэх гэх ойлголт ЗЕХ-ийн 58.1-т тусгагдсан байдаг ба түүнийг албан ёсны тайлбарт “тохируулан” хэрэглэх гэдэг нь иргэний эрх зүйн тухайн хэм хэмжээг эрх зүйн онол болон хэм хэмжээнүүдийн хувьд хэрэглэж болох эсэхийг шалгах²¹,.. (Ханнс - Зайделийн сан, 2017 он) гэж тайлбарласан байдаг. Үүнээс хамгийн гол анхаарах зүйл бол уг

²¹ Ханнс-Зайделийн сан, *өмнөх эшлэл 16, 273 дахь тал*

иргэний эрх зүйн хэм хэмжээ нь тухайн гэрээнд тохирох эсэхийг шалгахад оршино. Дээрх байдлаар хууль тогтоогчид нь “нөхөн тохируулж хэрэглэх” ойлголтод аунтетик тайлбар хийсэн байна.

ЗЕХ-ийн зохицуулалтаас гадна аунтетик тайлбараас үзэх юм бол ИХ-ийг захиргааны зарчим болон гэрээнд тохирч буй эсэхэд дүгнэлт өгч ИХ-ийн гэрээний заалтыг нөхөн хэрэглэх буй байдал бол субсидиар шинжтэй байна. энэ нь юу гэсэн үг вэ гэвэл эхлээд ЗЕХ дараа нь түүний салбар хууль үүний дараа зохицуулалт байхгүй гэж сая нэг үзэх юм бол ИХ-ийг нөхөн хэрэглэх нь өөрөө хоёрдогч шинжтэй гэж ойлгогдож байгаа юм.²²

Үүнээс дүгнэвэл, хоёрдогч байх гэсэн нь захиргааны гэрээ нь захиргааны хэм хэмжээнд үндэслэх буюу ЗЕХ болон салбар хуулиудын зохицуулалтуудад гэрээ байгуулах талаар хуульчилсан болон уг гэрээтэй холбоотой салбар хуулиудаар гэрээний харилцааг зохицуулсан хэм хэмжээ хэрэв байгаа бол хамгийн эхэнд ЗЕХ-ийн 5 дугаар бүлэгт хуульчлагдсан 52 дугаар зүйлээс 57 дугаар зүйл хүртэл буюу нөхөн хэрэглэх гэдгээс бусад хэсэгт нь уг харилцааг зохицуулсан байна уу? гэдгийг шалгаж, дараа нь нарийвчилсан зохицуулалт бүхий захиргааны гэрээний зорилго, агуулгыг зохицуулсан хуульд гэрээний талуудын харилцааг зохицуулж буй эсэхийг хянан шалгана. Үүний дараа хэрэв зохицуулалт байхгүй тохиолдолд ИХ-ийн суурь зохицуулалтыг нөхөн хэрэглэнэ.

Т.Мөнх-Эрдэнэ судлаач нь *“Иргэний хуульд заасан гэрээний суурь зохицуулалт гэдэгт ИХ-ийн ерөнхий ангийн, тэр дотроо үүргийн эрх зүйн ерөнхий ангийн холбогдох зохицуулалтуудыг хамааруулж ойлгоно. Үүргийн эрх зүйн тусгай ангийн зохицуулалт шууд хэрэглэгдэх боломжгүй”* хэмээн өөрийн өгүүлэлд дурдсан байдаг²³. Энэ нь үүргийн эрх зүйн тусгай ангийг нөхөн хэрэглэж болох болохгүй гэх асуултыг хөндөж байна. Гэвч практикт үүний дагуу тусгай ангийн зохицуулалтыг нөхөн хэрэглэдэггүй гэх нь өрөөсгөл гэж би судлаачийн зүгээс дүгнэсэн. Учир нь шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийсний дараа шүүхийн практикт талуудын хооронд байгуулсан гэрээнд иргэний хуулийн 343 дугаар зүйлийн зарим заалтыг нөхөн хэрэглэсэн шийдвэр гарсан байдаг. Үүнээс үүргийн тусгай ангийг ч хэрэглэж буй практикт бий болсон байгаа нь тогтоогдож байна гэж үзлээ.

²² Тэрбишийн Мөнх-Эрдэнэ, “Захиргааны гэрээнд иргэний хуулийн зохицуулалтыг нөхөн тохируулж хэрэглэх асуудал”, legaldata.mn, 2016, 4 дэх тал (Сүүлд үзсэн : 2026.03.04)

²³ Мөн тэнд.

Захиргаа нь бас нэгэн шалтгаан буюу хэрэв түүний доод эрэмбийн буюу илүү нарийвчилсан салбар хуулиудын зохицуулалт нь хийдэлтэй тохиолдолд ИХ-ийн зохицуулалтыг нөхөн хэрэглэж болдог байна. Энэ нь тухайн харилцааг зохицуулаагүй гэх агуулгаас өөр утгатай буюу ЗЕХ-тай зөрчилдөж байвал уг нарийвчилсан хуулийг хэрэглэх боломжгүй болох үр дагаварт хүрнэ. Энэ нь ИХ-ийг нөхөн хэрэглэх үндэслэл болж буй хэрэг юм.

ИХ-ийн гэрээний суурь зохицуулалтыг нөхөн хэрэглэхэд яг төрөлжүүлсэн хэлбэрээр хуульд тусгаж оруулаагүй харин ерөнхий байдлаар зааж өгсөн байдаг. Үүнээс эрх зүйч, хуульч нараас мөн голлон Захиргааны хэргийн шүүгчдээс зарчимтай уялдуулах тал дээр илүү мэдлэг, ур чадварыг шаардах болсон байна. Энэ нь нийтийн эрх зүйн зарчимтай уялдуулах болон гэрээнд тохирох эсэхийг шалгах аас үүдэн гарч байна.

2.5. ЗГ-нд ИХ-ийн гэрээний заалтыг нөхөн хэрэглэхийг хориглох буюу хязгаарлах нөхцөлүүд

Иргэний гэрээнээс ялгаатай талууд байдаг талаар дээр шинж чанараар нь өмнөх бүлэгт ялган таньсан харин үүнээс улбаалан захиргааны гэрээний онцлог буюу захирах захирагдах харилцаанаас үүдэн гэрээний талуудын “гэрээний чөлөөт байдал” гэх ойлголт хязгаарлагдмал байна. Иргэний эрх зүйн хэм хэмжээнд буюу ИХ-ийн 189.1-т зааснаар гэрээ байгуулагч талууд нь хууль зөрчихгүй хуулийн дагуу өөрсдийн гэрээний агуулга болон хэнтэй байгуулахаа чөлөөтэй сонгох эрхтэй байна.

Энэ нь гэрээ байгуулагч тал нь хэнтэй гэрээ байгуулах, ямар гэрээг байгуулах талаар өөрийн хүсэл зоригийн үүднээс чөлөөтэй байгуулахыг ойлгоно. Мөн түүнчлэн захиргааны гэрээ нь захиргааны байгууллага, эрх бүхий албан тушаалтантай гэрээ байгуулж буй этгээд буюу иргэн, хуулийн этгээдүүдтэй байгуулахад тэдгээрийн санал гаргавал түүнийг хүлээн авна гэхдээ шууд тохиролцон тусгах боломжгүй хэрэв захиргааны байгууллага хүлээн зөвшөөрсөн тохиолдолд л энэ нь хэрэгжих боломжтой. Захиргааны гэрээ нь өөрөө “хууль ёсны байх” зарчмын дагуу зөвхөн гэрээг байгуулах талаар ЗЕХ болон салбар хуулиудад заасан тохиолдолд буюу захиргааны хэм хэмжээнд үндэслэн гэрээг байгуулдаг.

Уг хэм хэмжээнд үндэслэх гэдгээс захиргааны гэрээ нь өөрөө ИХ-ийн 189.5 дахь хэсэгт хуульчлагдсан гэрээ биш буюу нэрлэгдээгүй гэрээ байх боломжгүй. Салбар хуулиудад захиргааны гэрээ заагдсан гэх үндэслэлтэй юм.

ЗЕХ-ийн 56.1-т “... бүхэлдээ өөрчлөгдсөн..²⁴” гэж заасан ба энэ хуулийн 56.2-т “Өөрчлөх боломжгүй, эсхүл гэрээний аль нэг тал өөрчлөлт оруулахгүй гэж үзвэл захиргааны гэрээг цуцална²⁵.” гэж хуульчилж өгсөн байдаг. Үүнээс урган гарч ирэх зүйл нь юу байх вэ? гэвэл ИХ-ийн 220.1-т “гэрээ байгуулах үндэслэл болсон нөхцөл байдал ... илтэд өөрчлөгдсөн, и²⁶” талаар заажээ. ИХ-ийн 220.4 дэх хэсэгт заасантай ЗЕХ-ийн 56.2 дахь заалттай адил буюу гэхдээ зөвхөн татгалзах байдлаар зохицуулжээ. Харин ЗЕХ-д зааснаар гэрээнээс татгалзах бус цуцлах хэмээн томъёолж өгсөн нь захиргааны гэрээ нь ихэвчлэн урт хугацааны гэрээ байдаг бөгөөд үйл ажиллагааг тасралтгүй хурдан хийгдэхийг зорьдгоороо гэрээнээс татгалзах буюу өгсөн авснаа шууд буцаах боломжгүй үр дагавартай байдгаараа ийнхүү онцлог зохицуулалт болжээ.

ЗЕХ-ийн 55 дугаар зүйлд Захиргааны гэрээг илт хууль бус байх үндэслэлийг заасан байдаг. Иймд ЗЕХ-д хуульчлагдсан байх тул ИХ-ийн 56.1-т заагдсан гэрээ хүчин төгөлдөр биш байх тохиолдлуудад хэрэглэгдэхгүй байна.

2.6. ЗГ-нд ИХ-ийг нөхөн тохируулж хэрэглэж болох тохиолдлууд

Дараах 4 тохиолдолд ИХ-ийн зохицуулалтыг нөхөн хэрэглэх боломжтой байна. Үүнд:

- **Гэрээ байгуулах шатанд хэрэглэгдэх зохицуулалт**
- **Захиргааны гэрээг дүүсгавар болгох шатанд хэрэглэгдэх зохицуулалт**
- **Захиргааны гэрээ нь Илт хууль бус болсон тохиолдолд түүний эрх зүйн үр дагаар буюу хохирлыг арилгуулах**
- **Үүргийн зөрчлийн үлмаас үүссэн өөрт үчирсан хохирлыг шаардах зохицуулалт**

Гэрээ байгуулах үе шат

Гэрээг талууд харилцан хүсэл зоригоо илэрхийлснээр байгуулдаг. Нэг талын гэрээ байгуулах санал, нөгөө тал нь саналыг хүлээн авагч тал хүлээн зөвшөөрснөөр гэрээ байгуулагддаг байна. Тэгвэл энэ талаар ИХ-ийн суурь зохицуулалт буюу энэ хуулийн 40.1 дэх хэсэгт зааснаар гэрээ байгуулах талуудын хүсэл зориг нь хүчин төгөлдөр байхын тулд нөгөө тал нь уг хүсэл зоригийг нь хүлээн авсан байх хуулийн шаардлагыг тусгажээ. Мөн түүнчлэн үүний дараа уг хүсэл зоригоороо гэрээний гол нөхцөлийг тодорхойлсон гэрээ

²⁴ ЗЕХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэг

²⁵ ЗЕХ-ийн 56 дугаар зүйлийн 56.2 дахь хэсэг

²⁶ Иргэний хуулийн 220 дугаар зүйлийн 220.1 дэх хэсэг

байгуулах саналыг гаргах нь уг гэрээ байгуулах үе шатанд ИХ-ийн зохицуулалт хамаарч буйг харж болно.

Захиргааны гэрээг цуцлахтай холбогдүүлэн хэрэглэгдэх зохицуулалт

Гэрээг цуцлах талаар ЗЕХ-ийн 56.2 болон 56.3 дугаар хэсгүүдэд хуульчилж өгсөн байдаг. Хамгийн түрүүнд 56.2 дахь хэсэгт заасны дагуу захиргааны гэрээг байгуулснаас хойш гэрээний гол нөхцөл буюу голлох ач холбогдол байсан гэрээний харилцаа нөхцөл байдал эрс өөрчлөгдсөн ба уг өөрчлөлтийг талууд тохиролцож чадаагүй эсвэл гэрээний хуучин заалтыг дахин өөрчлөх боломжгүйгээс үүдэн гэрээг цуцлах тохиолдлыг хэлдэг байна. Мөн хуулийн 56.3 дахь хэсэгт нийтийн сайн сайханд уг гэрээ нь ноцтой аюул учруулах бол уг гэрээг цуцлах талаар зохицуулжээ. Эдгээр заалтууд нь төрөлжсөн салбар хуульд заасан гэрээг цуцлах зохицуулалтаас дээгүүр тавигдана. Гэхдээ уг зохицуулалтыг хэрэглэх нь зөвхөн уг 2 заалтад дурдсан нөхцөл бий болсон тохиолдолд хэрэглэх явдал юм.

Харин уг ЗЕХ-ийн зохицуулалт болон салбар хуулиуд дахь зохицуулалтад хамаарагдахгүй өөр нөхцөл байдлын улмаас гэрээг цуцлах бол ИХ-ийн 204, 205, 221, 225, 227 дугаар зүйлүүдийг нөхөн тохируулж хэрэглэнэ. Үүнээс нэгэн анхаарах асуудал нь захиргааны гэрээнээс татгалзах талаарх ойлголт байхгүй. Учир нь захиргааны гэрээ нь өөрөө илүү том хэмжээнд урт хугацаа зарцуулагдах гэрээ хэлцлийг ойлгодог тул өгсөн авснаа буцаах хэмжээний амар зүйл биш ярвигтай асуудал байдаг. Үүнээс улбаалан ИХ-ийн гэрээнээс татгалзах харилцаанд 204, 205, 221, 227 дугаар зүйлүүд хамаардаг бол хуульд маш онцлогтой нь уг татгалзах болон цуцлах зохицуулалтыг тус тусад нь биш харин гэрээг цуцлах харилцаанд дээрх гэрээнээс татгалзах зохицуулалтаас гадна нэмж 225 дугаар зүйлийг хэрэглэхээр заасан нь анхаарах асуудал юм.

Захиргааны гэрээ нь нь Илт хууль бус болсон тохиолдолд түүний эрх зүйн үр дагаар буюу хохирлыг арилгуулах

Хохирлыг арилгахын тулд ИХ-ийн 56.5, 56.6 дахь хэсэг болон 492 дугаар зүйлүүдийг үндэслэн хамтад нь хэрэглэх замаар нөхөн тохируулж хэрэглэж болдог байна.²⁷ Мөн түүнчлэн ЗЕХ-ийн 55 дугаар зүйлд илт хууль бус байх тохиолдлуудад ИХ-ийн 58-аас 60 дугаар зүйл хүртэл нөхөн хэрэглэгддэг байна.

²⁷ Тэрбишийн Мөнх-Эрдэнэ, *өмнөх эшлэл 22, 11 дэх тал*

Үүргийн зөрчлийн улмаас үүссэн өөрт учирсан хохирлыг шаардах зохицуулалт

ИХ-ийн 219 дүгээр зүйлд хохирлыг шаардах эрхийг хуульчилсан байдаг ба захиргааны гэрээний улмаас нэг талын буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй өөрт учирсан хохирлыг эрх зөрчигдсөн тал нь уг заалтын дагуу шаардах эрхтэй байна.

Бүлгийн дүгнэлт :

Хоёрдугаар бүлэг нь захиргааны гэрээ нь ЗЕХ-д хэрхэн хуульчлагдсан талаар болон иргэний эрх зүйн гэрээнээс ялгагдах онолын ойлголтууд болон иргэний гэрээнээс ялгагдах шинжүүдийг харьцуулсан болно. Мөн түүнчлэн захиргааны гэрээ болон захиргааны актын шинжүүдийг харьцуулан судалсан ба уг судалгааны ажлын гол хэсэг болох иргэний хуулийн гэрээний суурь зохицуулалтыг нь захиргааны гэрээнд нөхөн хэрэглэх үндэс суурь болон иргэний хуулийн зохицуулалтыг нөхөн хэрэглэж болох тохиолдол болон болохгүй тохиолдлуудын талаар судалгааг хийж гүйцэтгэсэн болно.

Нэгдүгээр хэсэгт, захиргааны гэрээ нь ЗЕХ-ийн 52 дугаар зүйлд тусгагдсан ба захиргааны гэрээтэй холбоотой эрх зүйн зохицуулалт нь уг хуулийн 52 дугаар зүйлээс 58 дугаар зүйл хүртэл хуульчлагдсан байдаг болно. Мөн захиргааны гэрээг хэрэглэх харилцаанууд нь ЗЕХ-д нэмэлт, өөрчлөлт оруулсны дараагаас Концессын тухай хууль хүчингүй болж Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиар зохицуулагдахтай холбоотойгоор “концесс” гэх харилцаа байхгүй болсон ба “төр хувийн хэвшлийн түншлэлийн төслөөр хэрэгжүүлэхгүй үлдсэн дэд бүтэц болон бусад боловсрол, эрүүл мэндтэй холбоотой харилцаанд хамаарна гэж хуульчилсан байдаг. Үүнээс шинээр батлагдсан хуулийн дагуу хасагдсан ба ийнхүү хасагдсан нь уг Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиар зохицуулагдах түншлэлийн гэрээтэй холбоотой харилцаа нь иргэний эрх зүйн гэрээний шинжийг агуулна хэмээн үзэн “иргэний эрх зүйн гэрээ” гэж үзсэнтэй холбоотой байна.

Хоёрдугаар хэсэгт, захиргааны гэрээг иргэний гэрээгээс ялгагдах 4 онолын талаар судалсан. Мөн эдгээр онолууд нь нэгдсэн тодорхой шалгуур хараахан болоогүй болно. Онолын хувьд субъектын, ашиг сонирхлын, гэрээний зүйлийн онол, шатлалын гэх төрөлтэй байна. Гэрээ байгуулагч талууд нь тэгш бус буюу нэг талд заавал захиргааны байгууллага байх нь уг гэрээг захиргааны гэрээ гэж үздэг мөн гэрээний гол нөхцөл гэрээний зүйл болох объект нь аль эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж буй болон уг гэрээгээр нийтийн ашиг сонирхол хөндөгдөж буй эсэхээс хамааруулан, шатлалын дагуу тодорхой эрх зүйн хэм хэмжээнд тусгайлан чиг үүрэг, бүрэн эрх олгосон эсэхийг харгалзан уг онолуудаар зааглан ялгадаг байна.

Гуравдугаар хэсэгт, захиргааны гэрээ нь захиргааны үйл ажиллагаан дахь нэг хэлбэр болон хуульчлагдсан захиргааны актаас хэрхэн ялгагдах талаар авч үзсэн. Үүнээс

тэдгээрийн хоорондоо ялгагдах хамгийн том онцлог нь захиргааны акт нь өөрөө захиргааны байгууллагаас гаргаж буй зөвхөн нэг талын хүсэл зоригийн үүднээс бие даан ганцаараа шийдвэр гаргадаг эрх зүйн баримт бичиг, харин захиргааны гэрээ нь гэрээ байгуулагч нөгөө талын хүсэл зориг саналыг харгалзан тэдгээртэй зөвшилцөж байгуулдагаараа талуудын хүсэл зоригийн үндсэн дээр хамтын ажиллагаа хийж буй нэг хэлбэр болдог. Иймд нэг талын хүсэл зоригийн үүднээс үү, нөгөө талтай харилцан зөвшилцөн тохиролцож буй эсэхээс хамааруулан ялгах боломжтой. Гэхдээ үүнд дийлэнх захиргааны гэрээ нь гэрээний ерөнхий нөхцөлийг нөгөө талын саналгүй тулгасан байдаг боловч гэрээ байгуулагч нь уг нөхцөлийг хүлээн зөвшөөрч буй хэлбэр нь өөрөө гэрээ байгуулж буй хэлбэр гэдгийг ойлгох хэрэгтэй.

Дөрөвдүгээр хэсэгт, захиргааны гэрээний талаарх зохицуулалт нь ЗЕХ-ийн 52-оос 57 дугаар зүйл хүртэл зохицуулсанаас гадна салбар хуулиудад тусгайлан гэрээтэй холбоотой зохицуулалтууд хүртэл тусгагдсан байдаг боловч эдгээр нь гэрээтэй холбогдох бүхий л харилцааны хэсгийг зохицуулсан гэсэн үг биш. Гэрээний талаарх суурь зохицуулалт, тусгай зохицуулалт бүр нь ИХ-иар зохицуулагддаг иймд ЗЕХ болон төрөлжсөн салбар хуулиудад тусгагдаагүй байвал ИХ-ийн гэрээний суурь зохицуулалтыг захиргааны эрх зүйн зарчимд нийцүүлэн нөхөн тохируулж хэрэглэх үндэс суурь болдог байна.

Тавдугаар хэсэгт, захиргааны гэрээнд иргэний хуулийн ямар зохицуулалтыг ямар тохиолдолд нөхөн тохируулж хэрэглэхгүй талаар энэхүү хэсэгт судалсан. ЗЕХ-нд захиргааны гэрээтэй холбоотойгоор 52-57 дугаар зүйл заалтаар зохицуулагддаг ба үүнээс хамгийн гол хэсэг нь ИХ-ийн 189 дүгээр зүйлийн 189.1 дэх хэсэгт заасан гэрээний чөлөөт байдлын зарчим болох талууд харилцан чөлөөтэй агуулга, нөхцөлийг сонгох асуудал нь захиргааны гэрээнд хамаардаггүй байна. Мөн түүнчлэн гэрээг байгуулсны дараа нөхцөл байдал өөрчлөгдөхтэй холбоотойгоор уг нөхцөл байдлаас улбаалан гэрээг өөрчлөх шаардлагатай бол өөрчлөхийг шаардах эсвэл цуцлах талаар ЗЕХ-д тусгагдсан байх тул ИХ-ийн зүйл заалтыг нөхөн хэрэглэх шаардлага үүсэхгүй байна.

Зургаадугаар хэсэгт, захиргааны гэрээнд иргэний хуулийн зохицуулалтыг нөхөн хэрэглэж болох тохиолдлуудыг судалсан болно. Захиргааны гэрээнд ИХ-ийн зохицуулалтыг яг ямар тохиолдолд хэрэглэж байна вэ? гэвэл гэрээ байгуулах үе шатанд буюу гэрээ байгуулах санал түүнийг хүлээн авч хүлээн зөвшөөрсөн байдалд хамаарч байна. Мөн захиргааны гэрээг ЗЕХ болон түүний салбар хуулиудад зохицуулснаас бусад тохиолдолд ИХ дахь гэрээг цуцлах зохицуулалтыг хэрэглэх талаар мөн түүнчлэн уг цуцлах

зохицуулалтыг гэрээнээс татгалзах зохицуулалтаас зааглаагүйн улмаас татгалзах зохицуулалтыг хамт хэрэглэдэг. Захиргааны гэрээ илт хууль бус байх тохиолдол нь ИХ-ийн заалттай уялддаг болон гэрээний нэг талын буруутай үйл ажиллагаанаас болж нөгөө тал хохирол амссан бол уг хохирлыг ИХ-ийн 219 дүгээр заалтын дагуу шаардах эрхтэй гэх мэт тохиолдлуудад хэрэглэх нь байна.


Ш. БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Судалгааны хэсэг нь Монгол улсын шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх болон бодит практикт хийгдсэн захиргааны гэрээнд дүн шинжилгээ хийж аль хэсэгт иргэний хуулийн зохицуулалт орсон гэдгийг ялган таних мөн түүнчлэн гадаад улс орны эрх зүйн захиргааны гэрээний талаарх ойлголтыг харьцуулан судлахаар өөрийн төгсөлтийн ажлын хүрээнд судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.

3.1. Шүүхийн шийдвэрийн тоон үзүүлэлт


Захиргааны гэрээний маргаан нь Захиргааны хэргийн Улсын дээд шүүхийн тогтоол, тоон үзүүлэлт бүхий хэмжээгээр хянан шийдвэрлүүлсэн байдал, мөн түүнчлэн тэдгээрт маргааны төрлөөр гол эзлэх хувь хэмжээг Шүүхийн шийдвэрийн цахим сангаас хайлт хийж график байдлаар харуулсан болно.

Зураг 1. Захиргааны хэргийн Улсын дээд шүүхийн тогтоолд Захиргааны гэрээний маргааны төрөл тус бүр дэх эзлэх хэмжээг харуулав.



Эх сурвалж : Монгол улсын шүүхийн шийдвэрийн цахим сан

Зураг 2. Захиргааны хэргийн Улсын дээд шүүхийн тогтоолд Захиргааны гэрээний маргааны төрөл тус бүр дэх эзлэх хэмжээг харуулав.



Эх сурвалж : Монгол улсын шүүхийн шийдвэрийн цахим сан

3.2. Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ

Иргэний хуулийн зохицуулалтыг нөхөн хэрэглэсэн Захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлэгдэн Анхан, Давж заалдах, Улсын дээд шатны шүүхээр тус бүр шийдвэрлэгдсэн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийв. Мөн түүнчлэн эдгээрээс иргэний хуулийн гэрээний суурь зохицуулалтыг нөхөн хэрэглэсэн болон ИХ-д заагдсан гэрээний тусгай зохицуулалтыг хүртэл уг захиргааны гэрээнд холбогдуулан илүү нарийвчилсан гэх үндэслэлээр нөхөн тохируулж хэрэглэж буй практик нь энэхүү шүүхийн шийдвэрийн судалгааны хэсэгт гарсан болно.

Хүснэгт III-1. *Шүүхийн шийдвэр №1*

№	Шүүхийн шийдвэрийн товч утга	
1	Шийдвэрлэсэн шүүх, шийдвэрийн нэр, огноо	Захиргааны хэргийн ДЗШ шүүхийн 2021/10/27-ны өдөр 221/МА2021/0563 дугаар магадлал
2	Нэхэмжлэлийн шаардлага	“125 дугаар цэцэрлэгийн ажлын сунгалтын гэрээ”-ний үүргээ биелүүлээгүй хууль бус эс үйлдэхүй гаргасан болохыг тогтоолгож, нэмэлт ажлын төлбөр болох 280,829,358 төгрөгийг нэхэмжлэгчид олгохыг даалгуулах
3	Маргааны агуулга	“ПЭ” ХХК буюу нэхэмжлэгчийн шүүхэд гаргасан нэхэмжлэлд ...НХОГ мөн түүнчлэн БШУЯ “Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 240 орыг НХААГ -180074-2 дугаартай “125 дугаар цэцэрлэгийн ажлын сунгалтын гэрээ”-ний 5-ын б, 6-д заасныг үндэслэн 2020 оны 10 сарын талуудын хурлын тэмдэглэл мөн түүнчлэн уг оны 11 дүгээр сарын хурлын тэмдэглэлээр нэмэлт төлбөрийг шийдвэрлэсэн байдаг. Иймд уг нэмэлт ажлын төлбөрийг нэхэмжлэгчид олгохыг даалгуулах нэхэмжлэл гаргасан. Хариуцагч НХОГ, ОНААТҮГ-ын хариу тайлбартаа ...уг төсөл арга хэмжээний хөрөнгө оруулалт нь улсын төсвийн хөрөнгөөр байдаг үнээс үзвэл нэхэмжлэгчийн гаргасан нэхэмжлэл нь хангагдах үндэслэлгүй буюу уг төлбөрийг улсаас гаргасан жил бүрийн төсвөөс тавьж олгодог байхад хариуцагч нь дур мэдэн нэмэлт төлбөр өгөх боломжгүй иймд уг нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох нь зүйтэй, Хариуцагч БШУЯ-ны тайлбартаа ... “нэхэмжлэгч компанийн өгсөн тэр хүсэлтийн дагуу манайх хэлэлцэж, 2020 онд Сангийн яамнаас тухайн оны улсын төсвөөр хийгдэж байгаа барилгын ажилд нэхэмжлэгчийн шаардаад байгаа шиг нэмэлт төлбөрийг өгөх боломжгүй буюу санхүүжилт өгөхгүй талаар мэдэгдсэн байдаг тул нэмэлт санхүүжилтийн гэрээг байгуулахгүй гэж

		<p>нэхэмжлэгчид мэдэгдсэн нэхэмжлэлийг бүхэлд нь эс зөвшөөрсөн.²⁸</p>
4	<p>Шийдвэрлэсэн байдал</p>	<p>Анхан шатны шүүхийн шийдвэрт, ЗЕХ-ийн 11.1, 11.1.2, 52.1, 58.1, Иргэний хуулийн 343.1,343.5 дахь заалтуудыг үндэслэн нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шүүх шийдсэн байдаг. Харин ДЗШ шүүхийн магадлалаар хариуцагчийг буруу тогтоосон гэж үзэн нэмэлт төлбөрийг буюу санхүүжилтийг олгох эрх бүхий албан тушаалтан нь БСШУЯ гэж үзэн анхан шатны шийдвэрээс хариуцагчийг өөрчлөн үлдсэн хэсгийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.²⁹</p>

²⁸ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021 оны 10 сарын 27-ны өдрийн 221/МА2021/0563 магадлал,

https://shuukh.mn/single_case/4517?start_date=&end_date=&id=2&court_cat=3&bb=1

²⁹ ЗХДЗШШ-ийн 2021 оны 10 сарын 27-ны өдрийн 221/МА2021/0563

5	<p>ЗЕХ-ийн 58.1 дэх хэсгийг хэрхэн хэрэглэснийг авч үзвэл</p>	<p>Уг маргааны гол зүйл болох гэрээний талууд нь хэдий ЗЕХ-д заасан захиргааны гэрээг шүүх байгуулсан байна гэж үзсэн хэдий ч уг гэрээний гол нөхцөл түүнийг байгуулах шалтгаан мөн түүнчлэн үр дагаврыг нь харгалзан үзэж уг барилгын ажлын гүйцэтгэл үр дүн нь өөрөө хамгийн чухал гэрээг байгуулах шалтгаан байсан тул ИХ-д заасан ажил гүйцэтгэх гэрээний шинжтэй ижилхэн гэж шүүх үзсэн. Иймд уг ИХ-д заасан ажил гүйцэтгэх гэрээтэй холбогдуулан бусад холбогдох заалтуудыг хэрэглэх боломжтой гэж үзэн. Нэхэмжлэгч талын нэмэлт төлбөрийг шаардаж буй шаардлагыг ИХ-ийн 345.2-т заасны дагуу нэхэмжлэгч тал нь уг ажлыг гүйцэтгэж дуусгахын тулд урьдчилан тооцоолсон гэрээний төлбөрөөс гадна төлбөр гарсан бол хариуцагчид мэдэгдэх шаардлагатай уг заалтыг хангаж хариуцагчид мэдэгдсэн байна. Мөн түүнчлэн уг хуулийн 345.1-т заасныг мөн шүүх үндэслэсэн ингэхдээ уг заалтын гүйцэтгэгч нь өөрөө ажлыг гүйцэтгэх төсвийг зохиож болох зохицуулалтыг үндэслэсэн байдаг. Иймд ДЗШ шүүх нь ЗЕХ-ийн 58.1 дэх хэсгийг үндэслэн уг гэрээтэй холбогдуулан илүү нарийвчлан харилцааг зохицуулсан ИХ-ийн 345.1 болон 345.2 дахь заалтуудыг үндэслэж нэхэмжлэгч талын нэхэмжлэлийн шаардлага болсон нэмэлт төлбөрийг бүрэн гаргуулж шийдвэрлэсэн. Гэхдээ судлаачийн зүгээс уг ИХ-ийн гэрээний заалтыг нөхөн хэрэглэхдээ холимог гэрээ шиг үзсэн үү? эсвэл ажил гүйцэтгэх гэрээтэй ижил гээд үзсэн үү? яагаад ЗЕХ-д заасны дагуу гэрээний суурь бус тусгай ангийн зохицуулалтыг нөхөн хэрэглэсэн нь практикт их сонирхолтой гэж хэлж болохоор шийдвэр гэж үзэж байна.</p>
---	--	--

Хүснэгт III-2. Шүүхийн шийдвэр №2

№	Шүүхийн шийдвэрийн товч утга	
1	Шийдвэрлэсэн шүүх, шийдвэрийн нэр, огноо	Нийсэл дэх захиргааны анхан шатны шүүхийн 2025/12/19-ний өдөр 128/ШШ2025/0973 дугаартай шийдвэр
2	Нэхэмжлэлийн шаардлага	БЗСанд нэхэмжлэгчийн гаргасан өргөдлийг шийдээгүй эс үйлдэхүйг нь хууль бус болохыг тогтоолгох мөн талуудын хооронд байгуулагдсан гэрээг дуусгавар болгон зээлийн өр төлбөрөөс чөлөөлөх талаарх шийдвэрийг БЗСанд даалгах
3	Маргааны агуулга	Нэхэмжлэгч Ж.М-ийн шүүхэд гаргасан нэхэмжлэлд : Талууд нь 2008 онд нэхэмжлэгчийг гадаадад суралцуулахаар тухайн үед Сангийн сайд нь Гэгээрлийн сайдтай хамтран гаргасан 67/131 тоот тушаалыг баримтлан “Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 98 оны 67/131 тоот хамтарсан тушаалаар батлагдсан гадаадын өндөр хөгжилтэй улсуудын сургуулиудад суралцагчдыг сургалтын төрийн сангаас зардлыг нь даан сургах болсны дагуу нэхэмжлэгч болон түүний захиалагч бас СТСан нь гэрээ байгуулсны үндсэн дээр нэхэмжлэгч нь Солонгос улсад суралцсан.
4	Шийдвэрлэсэн байдал	Шүүх нь шийдвэрээ үндэслэхдээ ЗЕХ-ийн 58.1-т заасны дагуу ИХ-ийн гэрээний суурь зохицуулалтыг нөхөн хэрэглэсэн байдаг. Ийнхүү нөхөн хэрэглэж нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь ханган талуудын хооронд байгуулагдсан 2008 оны гэрээг дуусгавар болсон гэж үзэн нэхэмжлэгчийг зээлээс чөлөөлсөн талаарх шийдвэр гаргахыг хариуцагчид даалгаж шийдвэрлэсэн.

5	<p>ЗЕХ-ийн 58.1 дэх хэсгийг хэрхэн хэрэглэснийг авч үзвэл</p>	<p>ЗЕХ-ийн 58.1дэх хэсгийг хэрхэн хэрэглэснийг авч үзвэл :</p> <p>ЗЕХ-ийн 58.1-т заасныг шүүх үндэслэхдээ нэхэмжлэгч тал нь Солонгос улсад суралцан Монгол Улсдаа буцаж ирсний дараа гэрээнд заасны дагуу үүргээ бүрэн гүйцэтгэж энэ талаарх өргөдлийг хариуцагч руу явуулсан нь ИХ-ийн 42.9-т заасныг үндэслэн хариуцагч болох БЗС нь уг өргөдлийг хүлээн авснаас хойш нэхэмжлэгчид ямар нэгэн бичгээр эс хүлээн зөвшөөрсөн талаарх хариуг өгөөгүй нь маргааны явцад талууд маргаагүй тул хариу өгөөгүй гэж тогтоогддог тул нэхэмжлэгчийн өгүүлсэн өргөдлийг гэрээ байгуулах санал гэж үзэж хариуцагчийн уг саналд хариу өгөөгүй үйлдлийг нь үүнийг хүлээн зөвшөөрсөн үйлдэл гэж шүүх нь уг ИХ-ийн зохицуулалтыг нөхөн хэрэглэжээ. Мөн түүнчлэн хариуцагчийн ИХ-ийн 43.3-т зааснаар уг хүсэл зоригийг хүлээн авсан үйлдэл хийгдсэн тул гэрээг амаар эсвэл бичгээр биш харин бодит үйлдлээр хийгдчихсэн хэмээн шүүх үзсэн нь өмнөх гэрээтэй холбоотой харилцааг дуусгавар болгосон талаарх өргөдлийг гэрээ байгуулах нэгэн хүсэл зоригийн илэрхийлэл гэж тайлбарласан нь судлаачийн зүгээс мөн их сонирхол татсан. Энэ нь зөвхөн үүргээ биелүүлснээр гэрээг дуусгавар болгох харилцаанд дахин шинэ гэрээ байгуулах санал мэт заалтыг үндэслэсэн үү эсвэл уг үүргээ биелүүлсэн талаарх өргөдлийг хүлээн авсан үйлдэл нь хариуцагч хүлээн зөвшөөрсөн гэж үзэхийн тулд нөхөн хэрэглэсэн эсэх талаар надад асуултыг үүсгэсэн.³⁰</p>
---	--	---

Эх сурвалж: Shuukh.mn

³⁰Нийсэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 12 сарын 19-ний өдрийн 128/ШШ2025/0973 дугаартай шийдвэр, https://shuukh.mn/single_case/20060?daterange=2025-12-19%20-%202025-12-19&id=1&court_cat=3&bb=1

Хүснэгт III-3. Шүүхийн шийдвэр №3 :

№	Шүүхийн шийдвэрийн товч утга	
1	Шийдвэрлэсэн шүүх, шийдвэрийн нэр, огноо	Шийдвэрлэсэн шүүх, шийдвэрийн нэр, огноо : УДШ-ийн 2021/02/24-ний өдөр дугаар 001/ХТ2021/0050 тогтоол
2	Нэхэмжлэлийн шаардлага	Нэхэмжлэгч нь нэхэмжлэлийн шаардлагадаа... “НЗДТГ-ын даргын 03/4388 дугаар бүхий шийдвэрийг хүчингүй болгож, гэрээний дагуу хариуцагчийг тоног төхөөрөмж болон автомашиныг хүлээн авахыг даалгуулж мөн ГУББГ-ын зарласан тендерийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлага гаргасан байна.
3	Маргааны агуулга	Маргааны агуулга : ЗДТГ болон нэхэмжлэгч нарын гэрээг хариуцагч та нь өөрөө санаачлан цуцалсныг нэхэмжлэгч нь эс зөвшөөрч ийнхүү шүүхэд нэхэмжлэл гаргаснаар харин хариуцагч нь ЗЕХ-д зааснаар цуцалсан нь үндэслэлтэй гэж талууд маргадаг.
4	Шийдвэрлэсэн байдал	Шийдвэрлэсэн байдал : УДШ нь анхан шатны болон давж заалдах шатны шүүхүүдийн шийдвэр магадлалд дараах өөрчлөлтийг оруулдаг. Ингэхдээ шийдвэр, магадлалын тогтоох хэсэгт ТБОНӨХБАҮХАтХ-ийн 29.1 болон 29.2 дахь хэсгийг үндэслэн тогтоосон хэсгийг устгаж, 41.1.1 гэснийг нь мөн адил устан оронд нь уг хуулийн 40.1-ийг нэмж өөрчилж шийдвэрлэсэн. Мөн түүнчлэн ИХ-ийн 225.1-т заасан гэрээг цуцлах талаарх хуулийн зохицуулалтыг нэмж өөрчлөн хяналтын шатны гомдлыг нь хангахгүй шийдвэрлэсэн.
5	ЗЕХ-ийн 58.1дэх хэсгийг хэрхэн	ЗЕХ-ийн 58.1 дэх хэсгийг хэрхэн хэрэглэснийг авч үзвэл :

<p>хэрэглэснийг авч үзвэл</p>	<p>Шүүх нь талуудын хооронд байгуулсан гэрээнд гэрээнээс цуцлах нөхцөлийг тусгаагүйгээс үүдэн хууль тогтоомжийг үндэслэн гэрээнээс цуцлах талаар ТБОНӨХБАҮХАтХ-д хуульчлан зохицуулагдаагүй гэж үзэн ИХ-ийн 225.1-т заасны дагуу цуцлах нь зүйтэй гэж үзсэн. Ингэхдээ шүүх дараах байдлаар үндэслэдэг. Үүнд :</p> <p>1. Хариуцагч нь гэрээг цуцлах талаар шийдвэр гаргасан нь ЗЕХ-д заасан гэрээг цуцлах зохицуулалтыг үндэслэсэн байдаг. Үүнээс ЗЕХ-ийн 56.3-т заасан нөхцөл байдал шүүх үүсээгүй гэж үзсэн учир нь уг зохицуулалт нь эрх бүхий байгууллага болох захиргааны байгууллага нь гэрээг бие дааж нөгөө талын бус зөвхөн өөрийн санаачилгаар цуцалж болох талаар зохицуулдаг гэвч уг зохицуулалтыг хэрэглэхийн тулд урьдчилсан нөхцөл байх ёстой буюу уг гэрээ нь нийтийн ашиг сонирхолд ноцтойгоор хор уршиг үзүүлэх гэх нөхцөл байдал нь хэрэг маргааны явцад тогтоогдоогүй байдаг. Харин хариуцагч талын цуцалсан гэх үндэслэл нь нэхэмжлэгч хугацаандаа барааг хүлээлгэн өгөөгүй гэх үндэслэл байна гэж шүүх үзсэн ингэхдээ нэхэмжлэгчид хүргүүлсэн мэдэгдэлд үндэслэсэн болно. Ингээд шүүх нь шийдвэрийн үндэслэх хэсэгтээ ЗЕХ-ийн 58.1-т заасныг үндэслэж шийдвэрлэдэг. Учир нь гэрээний үүрэг биелүүлээгүй болон хугацаа хэтрүүлсэн талаарх зохицуулалт нь ЗЕХ болон түүний төрөлжсөн тэр дундаа гэрээний гол хууль болох ТБОНӨХБАҮХАтХ-д уг харилцаг зохицуулсан зохицуулалт байхгүй тул ИХ-д заасан гэрээний суурь зохицуулалтыг нөхөн хэрэглэх нь зүйтэй гэж үзсэн.</p> <p>2. ТБОНӨХБАҮХАтХ-д заасны дагуу талуудын хооронд байгуулсан гэрээг ИХ-иар зохицуулахаар уг хуулийн 40.1-т заасныг үндэслэн нэхэмжлэгчийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн байна.</p>
--------------------------------------	--

Эх сурвалж: Shuukh.mn

Хүснэгт III-4. Шүүхийн шийдвэр №4 :

№	Шүүхийн шийдвэрийн товч утга	
1	Шийдвэрлэсэн шүүх, шийдвэрийн нэр, огноо	Шийдвэрлэсэн шүүх, шийдвэрийн нэр, огноо : ДЗШШ-ийн 2021/01/28-ны өдөр дугаар 221/МА2021/0069 тогтоол
2	Нэхэмжлэлийн шаардлага	Нэхэмжлэгч нь нэхэмжлэлийн шаардлагадаа... Э ХХК нь нэхэмжлэхдээ : Баруун урт асгат Эрдэнэцагааны дэд станцын ажил буюу барилгын ажлыг байгуулахаар гэрээ байгуулсан байдаг бөгөөд уг ажлын үлдэгдэл төлбөрийг нэхэмжилсэн ба мөн уг төлбөрөөс гадна нэмэлт зардлыг гаргуулахыг шаардахад хариуцагч болох ЭХТ-н нарийн бичиг нь өгөхөөс татгалзсан үйлдлийг хууль бус болохыг нь тогтоолгож, уг төлбөрүүдийг олгуулахаар гэрээ байгуулахыг даалгах нэхэмжлэл гаргасан байна.
3	Маргааны агуулга	Маргааны агуулга : ЭХТ-н нарийн бичгийн дарга нь нэхэмжлэгчийн шаардсан төлбөрүүдийг гаргах боломжгүй буюу энэ нь улсын төсөвт батлагдсан зүйл байх ёстой гэх үндэслэлээр төлөөгүйгээс үүдэн нэхэмжлэгч нь уг төлбөр, нэмэлт зардлуудыг авахаар шүүхэд нэхэмжлэл гарган талууд маргадаг байна .
4	Шийдвэрлэсэн байдал	Шийдвэрлэсэн байдал : Анхан шатны шүүх нь нэхэмжлэгчийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэн түүнд уг нэмэлт зардал, үлдэгдэл төлбөрийг Хариуцагчаас гаргуулахаар шийдвэрлэсэн байна.
5	ЗЕХ-ийн 58.1 дэх хэсгийг хэрхэн	ЗЕХ-ийн 58.1 дэх хэсгийг хэрхэн хэрэглэснийг авч үзвэл :

<p>хэрэглэснийг авч үзвэл</p>	<p>Шүүх нь талуудын хооронд байгуулсан гэрээг захиргаан ы гэрээ гэж дүгнэсэн ба ЗЕХ-ийн 58.1 дэх зохицуулалтыг дараах байдлаар тайлбарлан шийдвэрийн үндэслэлээ болгосон байдаг. Үүнд :</p> <ul style="list-style-type: none"> - Гэрээг байгуулагч талуудыг тэгш эрх болон бие даасан зарчмыг үндэслэн нэхэмжлэгчийн шаардаж буй үлдэгдэл төлбөрийг гаргуулахыг хангаж хариуцагчийг яманы төсвөөс уг барилгын төсөлд тусгасан зардлыг улсын төсвөөс үл шалтгаалан төлнө гэж тайлбарласан. <p>31</p>
--------------------------------------	--

3.3. Захиргааны гэрээнд дүн шинжилгээ хийх нь, ярилцлагын арга

Практик дээр хийгдсэн Монголын төрийн байгууллага болон төрийн өмчит хувьцаат компаниудын захиргааны бодит гэрээнд дүн шинжилгээ хийхийг энэхүү хэсэгт зорилоо.


Энэхүү судалгаа нь эхлээд монголын төрийн байгууллага болон төрийн өмчит компаниудын жагсаалтыг гаргаж, тэдгээрээс ЗЕХ-ийн 52.2 дэх хэсэгт заасан захиргааны гэрээг хэрэглэж болох харилцаа тус бүрд хийгдсэн захиргааны гэрээнд дүн шинжилгээ хийвэл уг судалгааг бүрэн дүүрэн хийнэ гэж үзсэн болно.

Монголын Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нийт 67 байна. Үүнээс ТӨҮГ-16, ТӨХК-27, Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани-16, Төрийн өмчийн оролцоотой компани-8 гэж ангилагдсан байна. (Төрийн өмчийн бодлого, 2024).

Эдгээр төрийн өмчит болон төрийн оролцоотой 67 хуулийн этгээдүүдээс хуульд заагдсан харилцааны дагуу дараах байдлаар судлав. Мөн уг судалгаанд гэрээний төрлүүдийг нарийвчлан судалсан болно.


Зураг 3. Гэрээ байгуулсан төрийн байгууллага

³¹ Захиргааны хэргийн Давж Заалдах Шатны шүүхийн 2021/01/28-ны өдөр дугаар 221/МА2021/0069 тогтоол, https://shuukh.mn/single_case/3972?start_date=&end_date=&id=2&court_cat=3&bb=1



Эх сурвалж : (Нээлттэй нийгэм форум, www.iltodgereе.mn, 2026)

Зураг 4. Гэрээний төрөл



Эх сурвалж : (Нээлттэй нийгэм форум, www.iltodgereе.mn, 2026)

Практикт бодитоор байгуулагдсан Захиргааны дараах гэрээнүүдэд дүн шинжилгээ хийж гүйцэтгэсэн болно.

НЭГ. 2014 оны 9 сарын 6-ны өдөр Дөрвөлжин сумын газрын асуудал эрхэлсэн албан тушаалтан болон Баян Айраг Эксплорэйшн ХХК нарын хооронд байгуулагдсан “Гадаадын иргэн, ГХОААНБ-д газар ашиглуулах гэрээ”-нд дүн шинжилгээг хийв.

ХүснэгтIII-5. Захиргааны гэрээнд иргэний хуулийн зохицуулалтыг нөхөн хэрэглэснийг тогтоох

Бүлэг, зүйл	Иргэний эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулсан хэсэг :
Гурав. Газар ашиглагчийн эрх, үүрэг <i>3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэг</i>	<i>Газрын төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиар хэтэрсэн хоног тутамд алданги төлөх.</i>
Тав. Газрын талаарх эд хөрөнгийн зарим зохицуулалт <i>5 дугаар зүйлийн 5.1 дахь хэсэг</i>	<i>Газар ашиглагчийн өмчлөлд байгаа тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх өөр этгээдэд шилжвэл Монгол Улсын Иргэний хууль болон Газрын тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.</i>
Тав. Газрын талаарх эд хөрөнгийн зарим зохицуулалт <i>5.2 дахь хэсэг</i>	<i>Энэхүү гэрээгээр ашиглах газрыг хязгаартай ашиглах эрх бүхий газар ашиглагч байгаа болон ийнхүү ашиглахаар шаардсан бол түүний газар ашиглах нөхцөл, журам нь Иргэний хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.</i>
Тав. Газрын талаарх эд хөрөнгийн зарим зохицуулалт <i>5.3 дахь хэсэг</i>	<i>Гэрээ байгуулагч талуудын шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл</i> <i>3.Ашиглагдаж буй газартаа шинээр нэмж барилга байгууламж барих бол холбогдох хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөл авсан байна.³²</i>

Эх сурвалж : <https://www.iltodgerree.mn/>

Дүгнэлт : Уг гэрээний 3.5 дахь заалтад “алданги”-ийг оруулж өгсөн нь ЗЕХ болон бусад салбар хуулиудад байдаггүй ба ИХ-ийн 232.6-д заасан зохицуулалтыг нөхөн тохируулж хэрэглэсэн байна. Мөн түүнчлэн үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрх шилжих мөн газрыг ашиглахтай холбогдуулан гаргасан шаардлагад мөн адил ИХ-ийн зохицуулалтын

³²Нээлттэй нийгэм форум, 2026, <https://www.iltodgerree.mn/contracts/view/780>

дагуу шийдвэрлэхээр заажээ. Хамгийн сүүлд барилга байгууламж барих шаардлагатай бус харин шинээр барих боломжтой гэх үндэслэлээр энэ нь тухайн нөхцөлд хийх эсэхийг өөрсдөө шийдэх боломжтой байдлаар тусгасан нь захирамжилсан биш харин нөгөө талын хүсэл зориг буюу саналтай зөвшилцөж буй хэлбэр байна.

ХОЁР. 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн Баян-Өлгий аймгийн ЗДТГ болон “ССМонголиа” ХХК нарын хооронд байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-нд дүн шинжилгээ хийв.

Хүснэгт Ш-6. Захиргааны гэрээнд дүн шинжилгээ хийсэн нь

Бүлэг, зүйл	Иргэний эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулсан хэсэг :
Гурав. Гэрээний нэр томъёоны тодорхойлолт	3.4. "Хэлэлцээр/зөвлөгөөн" В) "гэрээний талууд аливаа асуудлаар өөрсдийн санал, дүгнэлтээ илэрхийлэх.."
Тав. Гэрээний хугацаа	5.2.Талууд Гэрээний хугацааг дуусахаас 30 хоногийн өмнө цаашид гэрээг сунгах, өөрчлөлт оруулах асуудлаар харилцан тохиролцоно.
Арван гурав. Бусад зүйлс	13.2. гэрээний бүх талууд харилцан зөвшөөрсөн бол гэрээний хугацааг сунгаж болно. ³³

Эх сурвалж : <https://www.iltodgeree.mn/>

Дүгнэлт : Энэхүү гэрээ нь Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу “ССМонголиа” ХХК буюу тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Захиргааны байгууллагатай ийнхүү гэрээ байгуулан ажилласан байна. Энэ хуулийн 42.4-т зааснаар гэрээг “нээлттэй, ил тод байлгана” гэж заасны дагуу уг гэрээг нээлттэй сайтаас авсан болно. Мөн энэхүү гэрээний 3.4 дэх заалтад талууд нь чөлөөтэй санал гаргах эрхтэй талаар заасан ба гэрээний 5.2, 13.2 дахь хэсгүүдэд тус тус талууд тэгш эрхийн хүрээнд буюу иргэний эрх зүйн гэрээний чөлөөт байдлын үндсэн дээр харилцан тохиролцож хугацааг сунгах боломжтой байдлаар оруулж

³³Нээлттэй нийгэм форум, 2026, : <https://www.iltodgeree.mn/>
<https://resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/02/02/dvcgxd5xm321qmxo/bayanulgi%20-%20SS%20Mongolia.pdf>

өгсөн нь талуудад иргэний эрх зүйн гэрээний чөлөөт байдлын зарчим тусгагдсан гэж үзэж байна.

ГУРАВ. 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 2026/43 дугаар бүхий Баянхонгор аймгийн засаг даргын төлөөлөгч болон “Би өү эл ди майнинг” ХХК нарын хооронд байгуулагдсан “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ”-нд дүн шинжилгээ хийв.

Хүснэгт Ш-7. Захиргааны гэрээнд дүн шинжилгээ хийсэн нь

Бүлэг, зүйл	Иргэний эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулсан хэсэг :
Хоёр. Засаг даргын эрх, үүрэг	2.1.3. "...ИТХ-аар баталсан төсөл арга хэмжээнээс тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй..., түүнтэй зөвшилцсөний үндсэн дээр..."
Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг	3.1.7.1. Мах хүнсний ногоог 100% тухайн орон нутгийн иргэн, аж ахуйн нэгжээс худалдан авах 3.1.7.2-оос 3.1.7.4 хүртэл болон 3.1.18 дахь хэсгүүдэд тухайн орон нутгийн иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан ажиллах
Долоо. Гэрээ хүчин төгөлдөр болох	7.3.Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. ³⁴

Эх сурвалж : <https://www.iltodgeree.mn/contracts/view/1874>

Дүгнэлт : Энэхүү гэрээ нь ЗЕХ-ийн 52.2.1 дэх хэсэгт заагдсан харилцаанд хамаарна. Энэхүү гэрээнд иргэний хуулийн зохицуулалтыг шууд нөхөн хэрэглэсэн хэсэг байхгүй боловч хуулийн этгээдийн санал, зөвшилцөл хэдий тухайн орон нутаг дахь гэсэн боловч яг аль иргэн хуулийн этгээд гэдгийг тодорхой тусгаагүй нь хуулийн этгээдэд түүний өөрийн шийдвэр гаргалтын хүрээнд тодорхой иргэн, аж ахуйн нэгжийг өөрөө сонгон гэрээ байгуулан ажиллах эрхийг сунгаж өгсөн гэрээ болжээ. Энэ нь уг гэрээ байгуулагдсанаас хойш уг гэрээний дагуу үйл ажиллагааг явуулахдаа хуулийн этгээдийн саналын дагуу мөн түүнтэй харилцан тохиролцож чөлөөтэй сонгох боломжтойгоор заасан гэж дүгнэлээ.

³⁴Нээлттэй нийгэм форум, 2026, <https://www.iltodgeree.mn/contracts/view/1874>

Мөн захиргааны гэрээний бүтэц, эрх зүйн зохицуулалт, маргаан шийдвэрлэх, иргэний хуулийг нөхөн тохируулж хэрэглэх хэрэглээний талаар төрийн худалдан авах ажиллагааны Төрийн захиргааны төв газрын даргаас тодруулж асуусан. Үүнд төрийн байгууллагаас байгуулах гэрээ нь батлагдсан жишиг стандарттай байдаг бөгөөд ерөнхий болон тусгай нөхцөл гэсэн хэсгээс бүрддэг. Тухайн гэрээг байгуулах хэлцлийн үе шатад гэрээний ерөнхий нөхцөлд өөрчлөлт оруулалгүйгээр, тусгай нөхцөлд тодорхой хэмжээний өөрчлөлт оруулж болдог. Мөн иргэний хуулиас захиргааны гэрээнд нөхөн хэрэглэж байгаа тохиолдолд хугацаа тооцох, үүргийн гүйцэтгэл хангах алданги тооцох, шүүх дээр очоод төлөөлөх эрхтэй этгээдийг тогтооход түлхүү ашигладаг байна.

3.4. ЗГ-д ИХ-ийн зохицуулалтыг нөхөн тохируулж хэрэглэх талаар гадаад орнуудын харьцуулсан судалгаа

Монгол улс нь эрх зүйн бүлүүд дотроос эх газрын бүлд ордог. Иймд уг эрх зүйн бүлд хамаарах захиргааны гэрээний зохицуулалт хөгжсөн улс орон болох ХБНГУ болон Франц улсын эрх зүйд харьцуулсан судалгааг хийж гүйцэтгэв.

ХБНГУ-ын захиргааны гэрээний судалгаа

ХБНГУ-ын эрх зүйн бүлийг сонгосон шалтгаан бол эрх зүйн хөгжлийн хүрээнд манай орны хувьд болон эх газрын эрх зүйн бүлтэй орнуудын хувьд хамгийн тэргүүлэх орон юм. Мөн түүнчлэн Монгол улсын ЗЕХ-ийг боловсруулахад ХБНГУ-ын нэрт эрдэмтэд санал өгсөн байдаг нь ач холбогдолтой бөгөөд захиргааны гэрээг байгуулан хамтын ажиллагааг эрчимтэй хийдэг орнуудын нэг юм. *Verwaltungsverfahrensgesetz (VwVfG)*- ЗХХШТХ-ийн 62 дугаар заалт Монгол Улсын ЗЕХ-ийн 58 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасантай ижил байна.

Хүснэгт III-8. *ХБНГУ-ын хуульд захиргааны гэрээнд иргэний хуулийн зохицуулалтыг нөхөн хэрэглэх талаар хуульчилсан тухайд*

Гадаад улсын нэр, хууль, холбогдох хэсгийн орчуулга, ойлголт.	Хуулийн зүйл заалт, түүний агуулга
ХБНГУ-ын ЗХХШТХ /Administrative Procedure Act (VwVfG)/-ийн 4 дүгээр бүлэгт Нийтийн эрх зүйн гэрээ гэх ойлголтыг хуульчилж өгчээ. Энэ хуулийн 62 дугаар зүйл заалтад “энэ хуулийн 54-өөс 61 дүгээр зүйлд	62. Supplementary application of provisions As far as sections 54 to 61 do not provide otherwise, the remaining provisions of this Act shall apply. The provisions of the Civil Code shall also

<p>оновчтой зохицуулалт байхгүй бол энэ хуулийн бусад заалтуудыг хэрэглэнэ. Иргэний кодексийн холбогдох зохицуулалтууд нөхөн хэрэглэгдэнэ.”</p>	<p>additionally apply as appropriate.³⁵ (Administrative Procedure Act /Verwaltungsverfahrensgesetz(VwVfG)/, 1976)</p>
---	--

Франц Улсын захиргааны гэрээний судалгаа

Франц Улс нь нийтийн ашиг сонирхлын үүднээс захиргааны гэрээг байгуулдаг ба түүхэн хөгжлийн үйл явцаас авч үзвэл, захиргааны эрх зүйг эх газрын эрх зүйн бүлд анхдагч гэж хэлэхэд хилсдэхгүй орнуудын нэг юм. Мөн түүнчлэн нэг онцлог тал нь захиргааны байгууллага нь хуулиар олгогдсон эрх хэмжээг бусдад шилжүүлэх боломжгүй байдаг байна.

Захиргааны гэрээ нь үндсэн дөрвөн төрөлтэй.

1. Ажил үйлчилгээ худалдан авах гэрээ
2. Концессын гэрээ буюу олон нийт- хувийн хэвшлийн хоорондын түншлэлтэй адил үзэл баримтлал бүхий бусад төрлийн гэрээнүүд
3. Нийтийн өмч, эд хөрөнгийг хувийн хэвшлээр захиран зарцуулахаар байгуулсан гэрээ.
4. Хөдөлмөрийн гэрээ – ихэнх захиргааны албан хаагчдын дийлэнх хэсгийг нийтийн үйлчилгээний ажилчид эзэлдэг ба тэдгээр нь захиргааны гэрээг огт байгуулдаггүй байна.³⁶

Кейс : NVwZ 1986, 554-Хугацаа хэтрүүлсний торгууль

Хэргийн нөхцөл : Талууд нь 1969 онд “*боловсруулсан тосыг тээвэрлэх гэрээ*” байгуулжээ. Уг гэрээнд заагдсаны дагуу тухайлсан нарийвчлан заасан хууль буюу Боловсруулсан тосны тухай хуулийн зохицуулалтад нийцүүлэн талууд нь нэхэмжлэгч талд хариуцагч нь татаас өгөхөөр харилцан тохиролцсон байна. Үүний дагуу татаас нэхэмжлэгч тал авдаг байсан ба 1975 онд татаасын хэмжээг өндөр тогтоож авах эсвэл хуульд заасан хэмжээнд авах ёстой гэх агуулгаар талууд маргалдаж шүүхэд хандан шийдүүлсэн байна.

³⁵ § 62 S. 1 VwVfG

³⁶ *Дам эшлэв* : René J.G.H. Seerden, “Administrative Law of the European Union, its Member States and the United States: A comparative Analysis”, 3rd ed., Cambridge, 2012, 18

ХДШ нь Иргэний хуулийн зохицуулалтыг нөхөн хэрэглэх эсэх талаарх тайлбар:

Ингэхдээ шүүх нь нэхэмжлэгчийг ХБНГУ-ын ИХ-ийн 2 | 288 дугаар зүйлийг баримтлан нэмж төлсөн татаасын хугацаа хэтрүүлсэний торгуулийг Германы төв банкнаас тогтоосноос 3% илүү авах шаардлага гаргасныг эрс эсэргүүцсэн байдаг. (Хууль зүйн үндэсний төв, 2006 он)³⁷ Шийдвэрлэхдээ ХДШ нь иргэний эрх зүйн хэм хэмжээг зөвхөн хэрэглэж болох талаар уг маргаантай асуудлын үндэслэл болж буй хууль буюу 3%-ийн татаас авах талаар зохицуулсан хуульд хуульчлагдсан үед л хэрэглэх ёстой гэжээ. Үүнээс захиргааны гэрээг шүүх нь буруу тайлбарласан гэж судлаачийн зүгээс үзсэн. Гэвч ХБНГУ-ын ЗХХШтХ-ийн 62 дугаар зүйл нь ИХ-ийн зохицуулалтыг заавал тухайлан заасан тохиолдолд л хэрэглэх талаар тусгаагүй буюу шүүхийн шийдвэрлэсэн байдлаа үндэслэж буй хэсгээс өөр агуулгатай байна.

Хүснэгт III-9. Шүүхийн шийдвэр №5

№	ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН НЭР, ОН САР ӨДӨР	МАРГААНЫ АГУУЛГА	ИРГЭНИЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ НӨХӨН ХЭРЭГЛЭСЭН БАЙДАЛ
1	КАНАД УЛС-ЫН Дээд шүүхийн : <i>Sharp v. Autorité des marchés financiers, 2023 SCC 29 шийдвэр юм.</i>	Кебек мужийн захиргааны эрх баригчид "инфляцыг хөөргөх, эдийн засгийг унагаах" зорилгоор Кэбэк мужид компани байгуулж, Кэбэкийн үнэт цаасны тухай хуулийг зөрчсөн гэж Британи Колумбын оршин суугчдын эсрэг захиргааны байгууллагад нэхэмжлэл гаргах эрхтэй байсан эсэх асуудал	Вагнер С.Ж., Жамал Ж. нараар ахлуулсан дүн шинжилгээний дагуу тухайн мужид оршин суудаггүй этгээдтэй холбоотой хэргийг захиргааны шүүх хянан шийдвэрлэх эрхтэй эсэхийг шийдвэрлэхэд Иргэний хуулийн зохицуулалт хэрхэн хэрэглэгдэхийг голчлон авч үзсэн (40 дүгээр зүйлд). Эцэст нь шүүх бүрэлдэхүүний олонхын үзэж байгаагаар захиргааны байгууллага нь өөрийн эрх мэдлийн хүрээг тодорхойлох эрхтэй, мөн олон улсын хувийн эрх зүйн дүрмүүдийг дагаж мөрдөх үүрэгтэй, мөн энэ тохиолдолд тухайн мужид оршин суудаггүй,

³⁷ Хууль зүйн үндэсний төв, *Захиргааны эрх зүй : шүүхийн практик, цуврал №138, 380 дахь тал*

			<p>харьяалалгүй этгээдийн эрх үүргийн (англ. extraterritorial jurisdiction) талаар тус мужийн иргэний хуульд тусгаагүй байсан. Гэсэн хэдий ч хуулийн холбогдох заалтуудыг удаан хугацаанд шинжилсний дараа Дээд шүүх Кэбэкийн эрх баригчид энэ хэрэгт нэхэмжлэл гаргах эрхтэй гэсэн дүгнэлтэд хүрсэн.</p>
2	<p>Дээд шүүхийн Ferme ViBer inc-ийн эсрэг Financière agricole du Québec, 2016 SCC 34, [2016] 1 SCR 1032</p>	<p>Энэ нь хариуцагч La Financière agricole du Québec ("La Financière")-ийн удирддаг Фермийн Орлогыг Тогтворжуулах Даатгалын Хөтөлбөр (англ. the Farm Income Stabilization Insurance Program) (2001) 133 G.O. 1, 1336 ("ASRA хөтөлбөр")-тэй холбоотой шийдвэр байв. Вагнер, Гаскон ЖЖ нарын бичсэн дийлэнх шалтгаанууд хууль зүйн ангиллын талаар байх бөгөөд тухайлбал хариуцагч, фермерүүд хоорондын харилцааны ангиллын талаарх хэд хэдэн үндэслэл дурдсан: "Хувийн эсхүл нийтийн эрх зүйн журам хэрэглэгдэх эсэхийг шийдэхийн тулд эхлээд ASRA хөтөлбөр нь аль эрх зүйн гэрээ болохыг тодорхойлох ёстой" (30 дугаар цогцолбор). Энэ нь "захиргааны гэрээ" гэсэн дүгнэлтийг дэмжиж бичсэн</p>	<p>Энэхүү гэрээний дэглэм нь нийгмийн сайн сайхны зорилгыг эрэлхийлж байгаа тохиолдолд энэ нь илүү үр дүнтэй байх болно. Энэ нь нийтийн эрх зүйн гэрээний зүйлтэй холбоотой ашиг сонирхол бөгөөд тухайн төрийн эрх мэдлийн захиргааны байгууллагын гэрээгээр олгогдсон бүрэн эрхийн хүрээг тайлбарлахад нөлөөлөх магадлалтай..Гэсэн хэдий ч төрийн эрх мэдэл хязгаарлагдмал байдаг. Энд яригдаж буй захиргааны гэрээний хүрээнд эдгээр хязгаарлалтууд нь нийтийн эрх зүйн процедурын шударга ёсны асуудал биш харин сайн санааны болон гэрээний шударга байдлын асуудал юм (48-49 дүгээр зүйл). Тиймээс "захиргааны гэрээ" гэсэн ойлголт, түүнтэй холбоотой тусгай дүрэм журам байдаг. ASRA хөтөлбөр нь даатгалын гэрээний 92 "Захиргааны эрх зүйн системчлэл, хэрэглээ: харилцан хамаарал" эмхэтгэл шинжийг хангаагүй нэрлэгдээгүй захиргааны гэрээ тул Кэбэк</p>

		хэдэн зуун үгс байдаг (46 дугаар цогцолбор).	<p>мужийн Иргэний хуулийн 1425, 1432 дугаар зүйлд заасан гэрээ тайлбарлах журмаар давж заалдах шатны шүүх шийдвэрлэх болно. Иймд маргааны гол асуултад хариулахын тулд, эдгээр зүйлсийг үндэслэл болгох шаардлагатай. Үүнд: La Financière нь өргөдөл гаргагчдын үйл ажиллагааны агуулга болсон холбооны тусламжийн хөтөлбөрийн дагуу авсан мөнгөн дүнг хамтад нь уялдуулах боломжтой эсэх. (66 дугаар цогцолбор) Жишгийн эрх зүйд тендертэй холбоотойгоор (хууль тогтоох төрийн оролцоог оролцуулахгүйгээр) нийтийн болон хувийн салбар хоорондын ямар ч ялгааг хүлээн зөвшөөрдөггүй: Төрийн байгууллагын байгуулах гэрээ болон хувийн корпорацуудын байгуулах гэрээний журам адил тэгш үйлчилдэг.³⁸</p>
--	--	--	---

Дээрх гадаад улсын шүүхийн практикаас үзвэл Герман болон Монгол улсын эрх зүйн зохицуулалт адил байна. Харин Франц улсын эрх зүйн зохицуулалтын хувьд гэрээний төрлөөс хамааран зарим тал дээр ялгаатай байсан нь харагдаж байна. Ингэхдээ иргэний хуулийн зохицуулалтыг нөхөн тохируулж хэрэглэхдээ талуудын эрх үүрэг, нийтийн ашиг сонирхлыг харгалзсан байна.

Бүлгийн дүгнэлт :

Энэхүү бүлэгт захиргааны гэрээтэй холбоотой маргааны тоон үзүүлэлт болон захиргааны гэрээнд ИХ-ийн зохицуулалтыг нөхөн хэрэглэсэн шүүхийн шийдвэрүүдэд дүн

³⁸Оттавагийн их сургуулийн Захиргааны эрх зүй, засаглалын тэнхимийн эрхлэгч Хууль зүйн доктор, Профессор Пол Дейлигийн “Захиргааны эрх Жишгийн эрх зүйн болон Эх газрын эрх зүйн өнцгөөс авч үзэх нь: Харьцуулсан дүн шинжилгээ”, 2024, 90,91,92, 94,95 дугаар тал <https://jtrii.mn/mn/>

шинжилгээ хийсэн болно. Мөн түүнчлэн бодит байгуулагдсан захиргааны гэрээний заалтаас аль хэсэгт ИХ-ийн зохицуулалт түүний зарчим агуулагдаж буй талаар дүн шинжилгээ хийж Монгол улсын эрх зүйн бүлд хамаарах эх газрын болон жишгийн эрх зүйг харьцуулан судалсан болно. Мөн нэмэлтээр ярилцлагын аргын хүрээнд зарим нэг мэдээллийг олж авсан талаар өгүүлнэ.

Нэгдүгээр хэсэгт, Шүүхийн шийдвэрийн тоон үзүүлэлт Шүүхийн шийдвэрийн цахим сангаас хайлт хийн график байдлаар харуулсан болно. Үүнээс дүгнэхэд захиргааны гэрээтэй холбоотой маргаан нь захиргааны акт болон захиргааны хэм хэмжээний акттай харьцуулахад харьцангуй бага байдаг байна. Мөн маргааны төрлөөр авч үзвэл тендер, ашигт малтмалтай холбоотой гэрээний маргаан илүү их байр суурийг эзэлж байна.

Хоёрдугаар хэсэгт, ИХ-ийн суурь болон тусгай зохицуулалтыг шүүх нөхөн тохируулж хэрэглэсэн талаар авч үздэг. Ингэхдээ гэрээний үүргийн зөрчил болон гэрээ байгуулах санал түүнийг хүлээн авсан гэж үзэх тохиолдол болон гэрээг цуцлах болсон гол шалтгаанаас үүдэн ЗЕХ-ийн бус харин ИХ-ийн зохицуулалтыг нөхөн тохируулж байгаа талаар авч үздэг.

Гуравдугаар хэсэгт, практикт бодитоор хийгдсэн захиргааны гэрээг нээлттэй ил тод байдлын дагуу цахим эх сурвалжаас авч дүн шинжилгээ хийсэн болно. Үүнд алданги болон нөгөө талын хүсэл зоригийг хүлээн авч гэрээ байгуулснаас хойш харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдэх талаар зохицуулсан нь ИХ-ийн зохицуулалтыг гэрээнд тусгасан үйлдэл тул захиргааны гэрээ байгуулагдахаас өмнө уг зохицуулалтыг талууд харилцан тохиролцож болдог. Иймд зөвхөн гэрээний үүргийн зөрчилтэй холбоотойгоор ИХ-ийг нөхөн тохируулж хэрэглэж буй гэх ойлголт буруу байна.

Дөрөвдүгээр хэсэгт, ХБНГУ болон Францын эрх зүйн зохицуулалтыг судалсан ба ХБНГУ-тай адил буюу ижил зохицуулалт Монгол улсад байдаг харин Францын хувьд илүүтэйгээр гэрээний төрлүүд зарим тал дээр өөр байсан гэх дүгнэлтийг энэхүү бүлэгт хийсэн болно.

ДУГНЭЛТ

Захиргааны гэрээ нь иргэд, хуулийн этгээдтэй байгуулан улс орны дэд бүтэц бүтээн байгуулалтыг хурдасгадаг нэгэн чухал захиргааны үйл ажиллагааны хэлбэр юм. Тиймээс захиргааны гэрээ нь цаашид улам өргөн байгуулагдах ба уг гэрээтэй холбоотой харилцаанд анхаарах шаардлагатай болно. Үүнээс нэг жишээ дурдахад талууд нь захиргааны гэрээ байгуулан захиргааны гэрээний дагуу хүлээсэн үүргээ харилцан тохиролцож болох хэлбэрээр зарим заалтыг оруулсан бол заримдаа шууд санал өгсөн ба үүнийг нь нөгөө талын хүсэл зоригоос хамаарахгүйгээр зөвхөн биелүүлэх захирах захирагдах шинж мөн адил орсон байдаг. Харин гэрээний талууд нь уг гэрээний заалтыг буруу ойлгон, гэрээний эрх чөлөөний онолын дагуу хэрэглэх нь зүйтэй гэж үзсэнээс гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх асуудал тулгардаг. Өөр нэгэн жишээг дурдвал, судалгааны ажилд хийгдсэн шүүхийн шийдвэрээс үзэхэд барилгын ажлыг хийж гүйцэтгэхээр харилцан тохиролцсон ба уг ажлын гүйцэтгэлийн талаар шаардахдаа шүүх нь ИХ-ийн 343 дугаар зүйлийн холбогдох заалтуудыг нөхөн хэрэглэх нь зүйтэй хэмээн шийдвэрлэсэн байгаа нь зөвхөн суурь зохицуулалтыг бус тусгай зохицуулалтыг хүртэл практикт нөхөн хэрэглэж буй нөхцөл байдал үүсэж байна.

Онолын эхний хэсэгт захиргааны гэрээний үүсэл түүхэн хөгжлийн явцад захирах-захирагдах харилцаанд хэрхэн тэгш эрхийн хүрээнд захиргаа нь гэрээ байгуулж болох талаар маргаантай байсны улмаас захиргааны гэрээ хүлээн зөвшөөрөгдөх хүртлээ багагүй цаг хугацааг туулсан болон түүний ойлголт, төрөл, онцлог шинж болон захиргааны актаас үндсэн шинжүүдийг дүгнэн харьцуулж ялгаа заагийг тогтоосон мөн иргэний эрх зүйн гэрээнээс онолын үүднээс ялган таних талаар судалсан. Харин онолын хэсгийн 2 дахь хэсэгт захиргааны гэрээнд Иргэний хуулийн суурь зохицуулалтыг нөхөн хэрэглэдэг ба судлаачийн зүгээс энэхүү судалгааны ажлаараа иргэний хуулийн зохицуулалтын нөхөн хэрэглэх үндэслэл, хэрэглэж болох болон болохгүй тохиолдлуудыг аль болох тодорхой бичив.

Судалгааны хэсэгт Иргэний хуулийн нөхөн хэрэглэсэн шүүхийн шийдвэрүүдэд ЗЕХ-ийн 58.1 дэх хэсгийг хэрхэн үндэслэж хэрэглэсэн талаар болон практикт хийгдсэн бодит гэрээнүүдэд дүн шинжилгээ хийсэн нь миний энэ судалгааны ажлын шинэлэг тал юм. Мөн гадаад орнуудын хуулийн зохицуулалтыг Монгол Улстай харьцуулсан. Уг төгсөлтийн ажлаас дүгнэхэд ЗЕХ-ийн 58.1 дэх хэсэгт заасан уг нөхөн тохируулж хэрэглэх асуудлыг гагцхүү захиргааны гэрээнд тохирох эсэх болон нийтийн эрх зүйн зарчимд уялдуулан нөхөн тохируулж хэрэглэх гэх ерөнхий байдлаар тусгасан нь аль тохиолдолд нөхөн хэрэглэх

хэрэглэхгүй болон хэрхэн нөхөн хэрэглэх талаар эрх зүйч, хуульчдад нэгэн сорилт гэж дүгнэсэн.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Захиргааны гэрээнд иргэний хуулийн гэрээний суурь зохицуулалтыг нөхөн хэрэглэхдээ практикт шүүх нь Иргэний хуулийн гэрээний суурь зохицуулалтаас гадна тухайн гэрээнд ач холбогдолтой гэж үзэн Иргэний хуулийн гэрээний тусгай ангийн зохицуулалтыг хүртэл нөхөн тохируулж хэрэглэж буй байдал судалгааны хэсэгт гарсан.

Үүнээс одоогийн хүчн төгөлдөр үйлчилж буй ЗЕХ-ийн 58.1 дэх заалтанд “Иргэний хуулийн гэрээний суурь зохицуулалт”-ыг нөхөн хэрэглэхээр заасан байдаг. “Гэрээний суурь зохицуулалт” гэдэгт Тэрбишийн Мөнх-Эрдэнэ судлаач нь *“Иргэний хуулийн ерөнхий ангийн, тэр дотроо үүргийн эрх зүйн ерөнхий ангийн холбогдох зохицуулалтыг хамааруулж ойлгоно. Үүргийн эрх зүйн тусгай ангийн зохицуулалт шууд хэрэглэгдэх боломжгүй.”* хэмээн тайлбарласан байдаг. ИХ-ийн “гэрээний суурь зохицуулалт” гэдэгт ИХ-ийн үүргийн эрх зүйн ерөнхий ангид хамаарах тул тусгай ангид заагдсан гэрээнүүдийн заалтуудыг нөхөн хэрэглэх нь одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хуулинд нийцээгүй байхад практикт нөхөн тохируулж хэрэглэж буй тохиолдол үүсээд байна.

Иймд “гэрээний суурь зохицуулалт” гэх нэр томъёонд Монгол Улсын Дээд шүүхийн албан ёсны тайлбар гаргах санал гаргаж байна. Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.4-т Улсын дээд шүүхийн бүрэн эрхийг хуульчилж өгсөн байдаг. Энэхүү бүрэн эрхэд *“Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах”* гэж заасан. Энэ нь нэг хуулийн тодорхой зохицуулалтыг шүүхүүд нь зөрүүтэй ойлгож шийдвэрийн үндэслэлээ тайлбарлаж буй эсэхэд хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтоох шаардлагатай бол хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтоох ач холбогдолтой байдаг.

2. Захиргааны гэрээ нь “Хуульд үндэслэх зарчим”-д үндэслэдэг тул хэдий захиргааны хэм хэмжээнд байхгүй бол иргэний эрх зүйн гэрээний суурь зохицуулалтыг нөхөн тохируулж хэрэглэнэ гэж заасан боловч “гэрээний чөлөөт байдлын зарчим”-ийг агуулсан Иргэний хуулийн 189.1 дэх хэсэг нь хэрэглэгдэх нь хязгаарлагдмал байдаг. Мөн түүнчлэн Иргэний хуульд тусгагдсан нөхцөл байдлаас шалтгаалан тухайн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тухай заалтыг мөн адил хэрэглэх боломжгүй байна. Эхний тохиолдолд зарчимд үндэслэсэн бол дараагийн нөхцөлд гэрээнд тохирох эсэхээс хамааруулж байна гэж үзсэн.

Иймд захиргааны гэрээнд хэрэглэж болох эсэх талаар уг судалгааны ажлаас дүгнэн үзэхэд илүү одоогийн хуулийн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох шаардлага бий гэж судлаачийн зүгээс үзэж байна. Ингэснээр шүүхийн практикт уг ЗЕХ-ийн 58.1 дэх хэсгийг нэг мөр ойлгож, эрх зүйн тодорхой байдал бий болгох ач холбогдолтой ба хуульчдад ч мөн адил энэхүү хэрэглэж болох болон болохгүй гэх ялгаа заагыг ойлгоход чухал ач холбогдолтой байна.

НОМ ЗҮЙ

Монгол хэл дээрх эх сурвалж :

Эрх зүйн эх сурвалж :

1. Захиргааны ерөнхий хууль, 2015 он
2. Иргэний хууль, 2002 он
3. Захиргааны хэргийн Давж Заалдах Шатны шүүхийн 2021 оны 10 сарын 27-ны өдөр 221/МА2021/0563 дугаар магадлал
4. Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 12 сарын 19-ний өдрийн 128/ШШ2025/0973 дугаартай шийдвэр
5. Улсын дээд шүүхийн 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 001/ХТ2021/0050 дугаартай тогтоол
6. Захиргааны хэргийн Давж Заалдах Шатны шүүхийн 2021 оны 01 сарын 28-ны өдрийн дугаар 221/МА2021/0069 тогтоол
7. Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, “Монгол төрийн уламжлалыг сэргээх үндэсний хөдөлгөөн”-ий тэргүүнтэй 2018 оны 04 сарын 11-ний өдөр байгуулсан “Жагсаал цуглаан бүртгэх тухай” гэрээ.

Гадаад хэл дээрх эх сурвалж :

Эрх зүйн эх сурвалж :

1. *Administrative Procedure Act /Verwaltungsverfahrensgesetz(VwVfG)/*, 1976 он.

НОМ:

Монгол хэлээрх :

1. Жан Жак Руссо, *Нийгмийн гэрээ*, Франц, 1972 он
2. Пүрэвдолгорын Одгэрэл, *Захиргааны эрх зүй : Ерөнхий анги*, Улаанбаатар хот, 2016 он
3. Бат-Эрдэнийн Буянхишиг, *"Иргэний эрх зүйн удиртгал"*, Улаанбаатар хот, 2012 он
4. Ханнс - Зайделийн сан, *Монгол улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар*. Улаанбаатар хот, 2017 он

5. Хууль зүйн үндэсний төв, *Захиргааны эрх зүй : Шүүхийн практик*. Улаанбаатар хот, 2006 он
6. Цэндийн Цогт, *Захиргааны хэргийн шүүх*, Улаанбаатар хот, 2019 он
7. Гочоогийн Банзрагч, “*Эдийн засгийн захиргааны эрх зүй*”, Улаанбаатар хот, 2013 он, 122 дахь тал

Гадаад хэлээрх :

1. *Дам эшлэв* : René J.G.H. Seerden (ed), *Administrative Law of the European Union, its Member States and the United States, A comparative Analysis*, 3rd ed., Cambridge, 2012, p.18

ӨГҮҮЛЭЛ:

Монгол хэлээрх :

1. Тэрбишийн Мөнх-Эрдэнэ, *"Захиргааны гэрээнд Иргэний хуулийг нөхөн тохируулж хэрэглэх асуудал"*, legaldata.mn, 2017 он, 4 дэх тал
2. Цэндийн Цогт, “Нийтийн эрх зүйн дэх зохицуулалтын арга: захиргааны гэрээ”, legaldata.mn, 2007 он.
3. Цэндийн Цогт, “Нийтийн эрх зүй дэх захиргааны гэрээ хувийн эрх зүйн гэрээнээс ялгагдах онцлог, шүүхийн хяналт”, *Хууль дээдлэх ёс*, 2007 он, 4 дэх тал
4. Оттавагийн их сургуулийн Захиргааны эрх зүй, засаглалын тэнхимийн эрхлэгч Хууль зүйн доктор, Профессор Пол Дейлигийн “*Захиргааны эрх Жишгийн эрх зүйн болон Эх газрын эрх зүйн өнцгөөс авч үзэх нь: Харьцуулсан дүн шинжилгээ*”, 2024 он,

Гадаад хэлээрх:

1. Batalli, A. I. (n.d.). *The Role of Administrative contracts in the field of public administration*, 394.

ЦАХИМ ЭХ СУРВАЛЖ :

Монгол хэл дээрх :

1. Төрийн өмчийн бодлого, з. г. , *Төрийн өмчит орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд*, Улаанбаатар хот, 2024 он
2. Нээлттэй нийгэм форум. 2026 он, www.iltodger.ee.mn.
3. 2014 оны 9 сарын 6-ны өдөр Дөрвөлжин сумын газрын асуудал эрхэлсэн албан тушаалтан болон Баян Айраг Эксплорэйшн ХХК нарын хооронд байгуулагдсан “Гадаадын иргэн, ГХОААНБ-д газар ашиглуулах гэрээ” Нээлттэй нийгэм форум, 2026, <https://www.iltodger.ee.mn/contracts/view/780>, (Сүүлд үзсэн : 2026.02.03)
4. 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн Баян-Өлгий аймгийн ЗДТГ болон “ССМонголиа” ХХК нарын хооронд байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”, Нээлттэй нийгэм форум, 2026, <https://resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/02/02/dvcgxd5xm321qmxo/bayanulgii%20-%20SS%20Mongolia.pdf>, (Сүүлд үзсэн : 2026.02.03)
5. 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 2026/43 дугаар бүхий Баянхонгор аймгийн засаг даргын төлөөлөгч болон “Би өү эл ди майнинг” ХХК нарын хооронд байгуулагдсан “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ”, Нээлттэй нийгэм форум, 2026, <https://www.iltodger.ee.mn/contracts/view/1874>, (Сүүлд үзсэн : 2026.02.04)

Хавсралт А

АСУУЛГА :

Төрийн худалдан авах ажиллагааны газрын Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга Б-тэй хийсэн ярилцлага

1. Төрийн худалдан худалдан авах үйл ажиллагааг зохицуулан байгуулдаг захиргааны гэрээ нь үндсэн ямар хэсгүүдээс бүрддэг вэ?

Хариулт : Тендер- Сангийн сайдын жишиг баримт бичиг байдаг үүний дагуу л хийдэг дээ. Тендэр шалгаруулахд оролцоод ялсан байгууллагатай байгуулах гэрээ буюу тендерийн гэрээний талаар асууж байх шиг байна. Сангийн сайдын жишиг баримт бичгүүд байдаг. Энэ нь ажил, бараа, үйлчилгээ тус бүрдээ өөр энэ жишиг баримт бичигт гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг оруулчихсан байдаг. Мөн тендерт оролцогчдын зааварчилгаа гээд урт талд нь 20-30 хуудас байдаг. Гэрээний хавсралтаар орж явдаг тэрийг өөрөөр өөрчлөөд байдаггүй, ерөнхий нөхцөлийг бол бүр өөрчилдөггүй, харин тусгай нөхцөл дээр нь тухайн арга хэмжээний онцлогдоо тулгуурлаад яамнаас жоохон өөрчлөлт хийж болно. Гэрээний хэлцлээр шийдэгдэнэ. Гэрээ нь ерөнхий болон тусгай нөхцөл гэсэн 2 гол хэсэгтэй, жишиг баримт бичиг дээрээ оруулчихсан байдаг.

1. Захиргааны гэрээнд Иргэний хуулийн суурь зохицуулалтаас оруулсан байдаг уу?
/жишээлбэл алданги/

Хариулт : Хугацаа тооцох, мөн түүнчлэн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, ерөнхий нөхцөл өөрчилдөггүй, тусгай дээр хэлцлээс хамаараад өөрчлөлт оруулж болно.

2. Шүүхийн маргааны харьяаллын хувьд дийлэнх тохиолдолд захиргааны шүүх рүү явж байгаа гэж ойлгож болох уу?

Хариулт : Тийм, захиргааны актын нэг төрөл учир захиргааны шүүх рүү явчихдаг, харин манай газраас нэхэмжлэл гаргаад тендерт оролцогчийг хариуцагчаар татаад иргэний шүүхээр явах тохиолдол байдаг, нөгөө тендер баталгаагаа улсын орлогод үлдээнэ үлдээхгүй гэх мэт, одоо бид хятадуудтай шүүхдэж байгаа 1.5 тэрбум төгрөгийг улсын орлого болгохгүй байгаа гэх нэхэмжлэлтэй нэг тийм кейс байна. Би энд ажиллаад 10 гаруй жил болж байна иргэний шүүх рүү явсан тохиодол тун цөөхөн нэг хоёр л байх. Яг захиргааны шүүх дээр очоод иргэний хуулийг хугацаа тооцох, итгэмжлэл зэрэгт тулгаж хардаг.

4. Гэрээнд эрх зүйн зохицуулалт дутмаг байх гэх мэт аливаа асуудал үүсдэг үү?


Хариулт : Гэрээнд айхтар асуудал үүсдэггүй. Гэхдээ манай хийх ажлууд тендерийг зохион байгуулах, шалгарсан байгууллагатай тендерийн хүчинтэй хугацаанд гэрээ байгуулах зөвлөмжийг холбогдох яамдуудад хүргүүлээд дуусчихдаг тул энэ асуултыг яамдуудаас тодруулж асуувал тохиромжтой байх.

5. Иргэний хуулийн зохицуулалтыг голчлон гэрээнд ямар байдлаар нөхөн тохируулж хэрэглэдэг вэ?

Хариулт : Ихэвчлэн хугацаа тооцох, итгэмжлэл олгох гэх мэт харилцаанд иргэний хуулийн зохицуулалтыг нөхөн хэрэглэдэг.

6. Танд жишиг баримт бичиг дээр өөрчлөх санал, дутмаг тал байгаа гэж хардаг уу?

Хариулт : Байгаа, байгаа Сангийн яам гэхээр төсөв бүрдүүлэх, төсөвлөх, зарцуулах бүхэл санхүүтэй холбоотой, олон улсын зээл тусламжууд гэх мэт юмнууд байгаа, энэ дээр нэг юм нь Монгол улсын худалдан авах ажиллагааны бодлогыг Сангийн яам барьдаг. Харин худалдан авах ажиллагаа нь Шадар сайд Доржханд гэж хүнд байна. Тэгээд ингэхээр манайх чинь шадар сайдын харьяа, 2 төсвийн ерөнхий захирагчийн доор үйл ажиллагаа явуулж байгаа. Нэгт. Энэ жишиг бичиг баримтыг сангийн яамны бодлогын газраас боловсруулж баталж байгаа, тэгэнгүүт тэр газарт эрх зүйч, хуульч мэргэжлийн хүмүүс тун цөөхөн 2-3 байгаа бусдаар санхүүч, эдийн засагч гэх мэт хүмүүс олон байгаа, энд миний бодлоор дан эрх зүйч нар байх хэрэгтэй. Хоёрт. Шүүх дээр хэрэг маргаан, байгууллага дээр гомдол санал ирдэг нь танай энэ бичиг баримтыг боловсруулж байгаа хүмүүсд хуульч нар алга аа гэх, миний мэдэхээр 2 хуульч байгаа, үе үеийн хэлтсийн дарга нар нь эдийн засагч нар байсан. Тэгэхээр тэд нар хууль эрх зүйн онол дутмаг, дарга нар тендерийг өөрийн харьяалалд явуулах сонирхолтой, тиймдээ ч саяхан шинэчлэгдсэн(2023 онд) хуулийг дахиад шинэчлэх гээд сууж байна. Мөн стандарт өөр өөр хэрэгжиж байгаатай холбоотой, боловсруулж байгаа хүмүүст нь асуудал байгаа гэж харж байгаа.



Тайлбар : Төрийн худалдан авах ажиллагааны газрын Төрийн захиргаа, удирдлагын газрын даргаас ярилцлага авсан нь